# НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
# 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 оны 12 дугаар сарын 05 Улаанбаатар хот

| Д/д | Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилго 1.** Нийслэлийн өмчийн хөрөнгийг эргэлтэд оруулж, өмч ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлж ажиллана. | | | | | | | |
| **Зорилт 1.** Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан бодлогын зорилтуудыг хангаж ажиллана. /НХТЖҮЧ-4.1.1, НЗДҮАХ-3.1.1, ХАХТ-3.1.1.2, 3.1.1.3, 3.1.1.5, 3.1.4.3/ | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ: 1.1.1<br>Нийслэлийн төсөвт орон нутгийн өмчийн түрээсийн орлогыг батлагдсан түвшнээр төвлөрүүлэх<br>*НХТЖҮЧ-4.1.1, НЗДҮАХ-3.1.1.2, ХАХТ-3.1.1.3* | - | Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлого, сая.төг | 1,973.8 сая.төг<br><br>637.7 сая төг *(хагас жил)* | 1,800.0 сая.төг | НИТХТ-ын 2014 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх журам"-ын дагуу иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудтай нийслэлийн өмчийн илүүдэлтэй байр талбайн нийт 142 түрээсийн гэрээг баталгаажуулан, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, жил бүр дүгнэн ажиллаж байна. 2024 оны түрээсийн жилийн орлогын төлөвлөгөөг 3,068.9 сая төгрөгөөр баталж, түрээсийн орлого төвлөрүүлэх батлагдсан хуваарийн дагуу 2024.06.30-ны өдрийн байдлаар 1,163.3 сая төгрөг, 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар 2,772.2 сая төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн. | 100% |
| 2. | Арга хэмжээ: 1.1.2<br>Нийслэл хотын хөгжлийг дэмжих, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх санхүүгийн шинэ эх үүсвэрийг бий болгох зорилгоор нийслэлийн өмчийн томоохон үл хөдлөх хөрөнгүүдийн зах зээлийн бодит үнэ | 200.0 | Зах зээлийн бодит үнэлгээг тодорхойлох барилга байгууламжийн тоо | 10 барилга | 2024 онд 9 барилга байгууламжийн зах зээлийн үнэлгээ хийлгэх сонгон шалгаруулалтын ажлыг зохион байгуулан, үнэлгээний тайланг тайлагнасан байна. | НЗДТ-ын захиалгаар 2022 онд НХААГ/200204431 тоот хөрөнгийн үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу Прайсвотерхаус Күүперс Эдвайзори ХХК (PwC) нийслэлийн өмчийн томоохон үл хөдлөх хөрөнгө 10 барилга байгууламжуудын зах зээлийн үнэ цэнийг тодорхойлсон. Үүнд:<br>*1.Нийслэлийн Засаг захиргааны 4-р байр*<br>*2.Нийслэлийн Төр захиргааны 2- байр А корпус*<br>*3.ХУД, ЗДТГ-ын барилга /шүүхийн барилга/*<br>*4.ХУД, ЗДТГ-ын барилга /татварын барилга/*<br>*5.Соёлын Төв өргөө* | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цэнийг тогтоох ажлыг зохион байгуулах<br>*НХТЖҮЧ-4.1.1, НЗДҮАХ-3.1.1, ХАХТ-3.1.1.5* | | | | | *6.Монголын хүүхдийн ордон*<br>*7.Хүүхдийн Жаргалан бүтээх төв*<br>*8.Нийслэлийн Засаг захиргааны 5-р байр*<br>*9.Гэрлэх ёслолын ордон*<br>*10.ХУД-ын Соёлын ордон*<br><br>Нийслэлийн өмчийн томоохон үл хөдлөх хөрөнгө болох барилга байгууламжуудын зах зээлийн үнэлгээг тогтоолгох судалгааг гарган Үнэлгээний санхүүжилтийн эх үүсвэрийн саналыг 2024 оны төсвийн төсөлд өргөн барьсан бөгөөд батлагдаагүй байна. | |
| 3. | Арга хэмжээ: 1.1.3<br>Нийслэлийн төсвөөс санхүүжиж буй орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон орон нутгийн өмчит хаалттай хувьцаат компанийн засаглалыг сайжруулж зохион байгуулалтын өөрчлөлт хийх<br>*НХТЖҮЧ-4.1.1, НЗДҮАХ-3.1.1.1, ХАХТ-3.1.1.2* | - | Байгууллагын тоо | НИТХ-ын 2022 оны 47 дугаар тогтоол, 2023 оны 10, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 711 дүгээр захирамжаар татан буулгах ажил үргэлжлэн хийгдсэн. | Нийслэлийн төсвөөс санхүүждэг 2 үйлдвэрийн газруудыг нэгтгэх, татан буулгах саналыг НИТХ-д өргөн барьж, шийдвэрлүүлнэ. | Засаглалыг сайжруулах ажлын хүрээнд:<br>1. “Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК<br>НЗД-ын 2024 оны А/311 дүгээр захирамжаар байгуулсан Ажлын хэсгээс тус компанийн анхны хувьчилсан байдал, түүнтэй холбоотой шүүхийн шийдвэрүүд, улсын бүртгэл дэх хуулийн этгээдийн бүртгэл, төсвийн хөрөнгө оруулалт, бүртгэл хөтлөлт, одоогийн хөрөнгийн байдал, ногдол ашиг хуваарилалт, газар, түүний өнөөгийн байдал зэрэг асуудлуудын хүрээнд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. НИТХ-ын 2024 оны 41 дүгээр тогтоолоор “Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК-ийн хувийн өмчийн хувьцааны хууль ёсны өвлөгчид өвлөх эрхээсээ татгалзах хүсэлт гаргасныг үндэслэн өр төлбөрт суутган тооцох хэлцэл хийж, орон нутгийн өмчид 100 хувь шилжүүлэн авах, улсын бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээг зохион байгуулахыг Нийслэлийн Засаг даргад зөвшөөрсний дагуу “Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК-ийн 51 хувийн өвлөгч Н.Булганбаатартай хэлэлцээр хийж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 01 дүгээр тогтоолоор 100 хувь нийслэлийн өмчид шилжүүлэн, 100 хувийн хувьцаа эзэмшигчээр НИТХ болгон өөрчилсөн.<br>Үйлдвэрийн газар өөрчлөн байгуулах ажлын хүрээнд: | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1. Засаглалыг сайжруулах ажлын хүрээнд 4 үйлдвэрийн газрыг хаалттай хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэн, дүрмийг батлуулсан. Үүнд:<br>- *НИТХ-ын 2024 оны 36 дугаар тогтоолоор “Багахангай үйлдвэрлэл, технологийн парк” ХК,*<br>- *НИТХ-ын 2024 оны 37 дугаар тогтоолоор “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ХК,*<br>- *НИТХ-ын 2024 оны 38 дугаар тогтоолоор “Налайх үйлдвэрлэл, технологийн парк” ХК*<br><br>2.Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Нийтийн зорчигч тээврийн үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 50 дугаар тогтоолын дагуу нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч ОНӨААТҮГ-ыг НИТХ-ын 2024 оны 28 дугаар тогтоолоор өөрчлөн байгуулж, дүрмийг шинэчлэн батлуулсан. Тогтоолын хэрэгжилтийг ханган дараах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд:<br>- *Зорчигч тээвэр нэг, Зорчигч тээвэр хоёр, Зорчигч тээвэр гурав, Зорчигч тээвэр дөрөв, Зоригч тээвэр тав ОНӨААТҮГ-ыг шинэчлэн байгуулан, дүрмийг баталж, улсын бүртгэлд бүртгүүлэн, бүтэц орон тоог батлуулан, удирдлагыг томилох, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж, хөрөнгийн эх үүсвэрийн хамт авлага, өр төлбөрийг тооцон шилжүүлэх ажлыг зохион байгуулан 2024 оны зорилтот түвшинг батласан.*<br>- *“Зорчигч тээврийн нэгтгэл”, “Зорчиг тээвэр гурав” ОНӨААТГ-ыг татан буулган, эрх үүрэг хариуцлага, хөрөнгийг шинээр байгуулсан нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч 5 ОНӨААТҮГ-т тус тус шилжүүлсэн.*<br><br><u>Үйлдвэрийн газар татан буулгах ажлын хүрээнд:</u><br>1. “Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт” ХХК-ийг НИТХ-ын 2024 оны 61 дүгээр тогтоолоор | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2024.04.30-ны өдрөөр тасалбар болон татан буулган, нийслэлийн Засаг даргын А/1344 дүгээр захирамжаар татан буулгах ажлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Үндсэн чиг үүргийн хүрээнд Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт ХХК-ийн хэрэгжүүлж байсан төслүүдийг дараах байгууллагуудад шилжүүлсэн. Үүнд:<br>- *ЗГ-ын 2023.11.22-ны өдрийн 411 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын хөндлөн чиглэлд метро нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд тус төслийг "Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж" УТҮГ-т*<br>- *"Шинэ тойрог зам" төслийг Нийслэлийн замын хөгжлийн газарт тус тус шилжүүлэхээр шийдвэрлэсэн.*<br><br>2."Нийслэлийн Засаг даргын 2024.05.10-ны өдрийн А/511 дүгээр захирамжаар"Улаанбаатар зүүн азийн наадам зохион байгуулах хороо" ХК-д бүртгэлтэй спортын хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжид тооллого хийх, бүртгэл, элэгдэл хорогдлыг тооцох үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан хөрөнгийг Монголын хүүхдийн ордонд, Нийслэлийн Бизнес инновац хөгжлийн газарт хүлээлгэн өгсөн.<br><br>3.Бэлчээрийн менежмент хэрэгжүүлэх төслийн нэгж ОНӨТҮГ-ыг НИТХ-ын 2024.06.18-ны өдрийн 87 дугаар тогтоолоор татан буулгасан. СХД-ийн Захиалагчийн алба ОНӨААТҮГ-д хөрөнгийг холбогдох журмын дагуу хүлээлцэн, хаалтын баланс аудитын дүгнэлт, архивын баримтуудыг хүлээлгэн өгсөн байна. | |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>4."Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор барилгын ашиглалтын өмнөх захиргаа" ОНӨТҮГ-ыг НИТХ-ын 2024 оны 129 дүгээр тогтоолоор татан буулгахаар шийдвэрлэн Нийслэлийн Засаг даргын 2024.11.04-ний өдрийн А/1298 дугаар захирамжаар татан буулгах ажлын хэсгийг байгуулан тус ОНӨТҮГ-ын балансt бүртгэлтэй нийт 36,573,200.00 төгрөгийн балансын үнэтэй хөрөнгийг "Шинэ зуун мод хөгжлийн корпорац"-д хүлээлгэн өгсөн.</td><td></td></tr>
<tr><td colspan="8">Зорилго 2. Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллах (Хуулиар тусгайлан олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилго)</td></tr>
<tr><td colspan="8">Зорилт 1. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай "Онцгой нөхцөлтэй хөдөлмөрийн гэрээ" байгуулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих, биелэлтийг дүгнэх, тухайн жилийн зорилтот түвшинг хянах, холбогдох шийдвэр гарган баталгаажуулах ажлыг зохион байгуулах (НИТХТ-ийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан журам)</td></tr>
<tr><td>4.</td><td>Арга хэмжээ: 2.1.1<br>Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын 2024 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшнийг батлуулах ажлыг зохион байгуулах</td><td>-</td><td>-Хуулийн этгээдийн тоо,<br>-Орлого, зарлага, алдагдлын мөнгөн дүн<br>-Нийслэлийн Засаг даргын захирамж гарсан байх</td><td>15 ОНӨААТҮГ-ын орлого 392.1 тэрбум, зардал 447.1 тэрбум, алдагдал 55.0 тэрбум төгрөгөөр баталсан.</td><td>ОНӨААТҮГ-ын 2024 оны зорилтот түвшний санал боловсруулах ажлын хэсэг байгуулна.<br><br>ОНӨААТҮГ-ын 2024 оны эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх зорилтыг батлуулна.</td><td>Нийслэлийн өмчит 15 аж ахуй тооцоот үйлдвэрийн газруудын 2024 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшинг хянан орлогыг 477.9 тэрбум, зардлыг 514.0 тэрбум, алдагдлыг 36.1 тэрбум байхаар санал оруулан Нийслэлийн Засаг даргын 2024.06.24-ний өдрийн А/755 дугаар захирамжаар батлуулсан. Үүнд:<br><br>1.ОСНААУГ ОНӨААТҮГ<br>Орлого-139,439,798.5 мян.төг<br>Зардал-159,103,302.3 мян.төг<br>Алдагдал-(19,663,503.8) мян.төг<br>2.УСУГ ОНӨААТҮГ<br>Орлого -130,455,649.9 мян.төг<br>Зардал- 133,792,633.8 мян.төг<br>Алдагдал-(3,336,983.9) мян.төг<br>3.Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ<br>Орлого-59,984,465.2 мян.төг<br>Зардал-59,984,465.2 мян.төг<br>Алдагдал- 0 мян.төг<br>4.Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ<br>Орлого-53,451,414.6 мян.төг<br>Зардал-60,629,653.3 мян.төг<br>Алдагдал-(7,176,238.7) мян.төг</td><td>100%</td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | *5.Геодези усны барилга байгууламж ОНӨААТҮГ<br>Орлого-15,159,457.1 мян.төг<br>Зардал-19,108,636.3 мян.төг<br>Алдагдал-(3,949,179.2) мян.төг<br>6.Хэсэгчилсэн инженерийн хангамжийн газар ОНӨААТҮГ<br>Орлого-14,578,769.0 мян.төг<br>Зардал-14,578,769.0 мян.төг<br>Ашиг,алдагдал-0<br>7.Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ<br>Орлого-13,031,318.0 мян.төг<br>Зардал-13,981,816.1 мян.төг<br>Ашиг-49,081.2 мян.төг<br>8. Хот тохижилтын газар ОНӨААТҮГ<br>Орлого-8,360,870.2 мян.төг<br>Зардал-10,905,080.1 мян.төг<br>Алдагдал-(2,544,209.9) мян.төг<br>9.Өсвөр үе хүнс" ОНӨААТҮГ<br>Орлого-11,465,951.1 мян.төг<br>Зардал-11,457,463.9 мян.төг<br>Ашиг-8,487.2 мян төг байхаар<br>10.Хүнс хангамж ОНӨААТҮГ<br>Орлого-7,881,499.7 мян.төг<br>Зардал-7,854,533.3 мян.төг<br>Ашиг-26,966.4 мян төг<br>11.Багачууд хүнс ОНӨААТҮГ<br>Орлого-5,823,002.8 мян.төг<br>Зардал-5,750,800.8 мян.төг<br>Ашиг-72,202.0 мян.төг<br>12.Асгат ОНӨААТҮГ<br>Орлого-4,090,550.0 мян.төг<br>Зардал-4,050,252.1 мян.төг<br>Ашиг-40,297.9 мян.төг<br>13.Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ<br>Орлого-6,354,836.0 мян.төг<br>Зардал-6,114,153.5 мян.төг<br>Ашиг-189,614.29 мян.төг* | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | *14.."Хот төлөвлөлт судалгааны институт" ОНӨААТҮГ*<br>*Орлого- 4,586,710.6 мян.төг*<br>*Зардал- 4,445,398 2. мян.төг*<br>*Ашиг- 141,312.4 мян.төг*<br>*15."Гэрлэх ёслолын ордон" ОНӨААТҮГ*<br>*Орлого- 2,274,386.0 мян.төг*<br>*Зардал- 2,255,550.8 мян.төг*<br>*Ашиг- 18,835 2 мян.төг*<br><br>Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1304 дүгээр захирамжаар нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх 5 ОНӨААТҮГ-ын зорилтыг баталсан. Үүнд:<br>*1.Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ*<br>*Орлого- 33,152,954,.5 мян.төг*<br>*Зардал- 35,443,661.7 мян.төг*<br>*Ашиг- (2,290,707.2) мян.төг*<br>*2.Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ*<br>*Орлого- 26,14419622.1 мян.төг*<br>*Зардал- 28,846,551.5 мян.төг*<br>*Ашиг- (2,434,919.4) мян.төг*<br>*3.Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ (шинэчлэсэн)*<br>*Орлого- 53,451,414.6 мян.төг*<br>*Зардал- 60,629,653.3 мян.төг*<br>*Ашиг- (7,178,238.7) мян.төг*<br>*4.Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ(шинэчлэсэн)*<br>*Орлого- 18,125,529.7 мян.төг*<br>*Зардал- 19,359,891.4 мян.төг*<br>*Ашиг- (1,234,361.7) мян.төг*<br>*5.Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ (шинэчлэсэн)*<br>*Орлого- 14,845,403.3 мян.төг*<br>*Зардал- 19,600,996.9 мян.төг*<br>*Ашиг- (4,755,593.6) мян.төг* | |
| 5. | Арга хэмжээ: 2.1.2<br>Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын 2023 оны эдийн засгийн | - | - Хуулийн этгээдийн тоо,<br>- Орлого, зарлага, алдагдлын мөнгөн дүн | Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/688 дугаар захирамжаар | ОНӨААТҮГ-ын 2023 оны зорилтот түвшнийг дүгнэх, ажлын хэсгийг байгуулан 2024 оны | Нийслэлийн өмчит 15-н ОНӨААТҮГ-ын захиралтай байгуулсан "Онцгой нөхцөлтэй хөдөлмөрийн гэрээ" дүгнэх шалгуур үзүүлэлт болох 2023 оны "Эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшин"-ийн үзүүлэлтүүдийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшнийг дүгнэх ажлыг зохион байгуулах | | -Нийслэлийн Засаг даргын захирамж гарсан байх | 15 ОНӨААТҮГ-ын зорилтот түвшин орлогыг 392.1 тэрбум, зардлыг 447.1 тэрбум, алдагдлыг 55.0 тэрбум төгрөгөөр баталсан. | 04 дүгээр сард дүгнэж дуусгана.<br><br>ОНӨААТҮГ-ын 2023 оны эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх зорилтот түвшнийг дүгнэсэн байна. | биелэлтийг дүгнэж Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/755 дугаар захирамжаар баталгаажуулсан. Үүнд 7-н үйлдвэрийн газрын захирлыг "бүрэн хангалттай", 8-н үйлдвэрийн газрын захирлыг "хангалттай" дүгнэн, 15 үйлдвэрийн газрын нийт орлого 462.5 тэрбум, нийт зардал 484.2 тэрбум, алдагдал 21.7 тэрбум төгрөгөөр буюу 2023 оноос алдагдал 35.5 тэрбум төгрөгөөр буурсан байна.<br><br><u>Алдагдлыг бууруулж ажилласан:</u><br>"Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ<br>*Зорилт- (19,473,306.0) мян.төг*<br>*Гүйцэтгэл-(8,060,202.6) мян.төг*<br>"Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ<br>*Зорилт-(18,579,670.1) мян.төг*<br>*Гүйцэтгэл-(7,631,225.5) мян.төг*<br>"Хот төлөвлөлт судалгааны институт" ОНӨААТҮГ<br>*Зорилт -149,595 3 мян.төг*<br>*Гүйцэтгэл-462,936 30 мян.төг*<br>"Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ<br>*Зорилт -946,921 3 мян.төг*<br>*Гүйцэтгэл-1,158,645 82 мян.төг*<br>"Гэрлэх ёслолын ордон" ОНӨТҮГ<br>*Зорилт -15,095 3 мян.төг*<br>*Гүйцэтгэл-531 ,298 00 мян.төг*<br><br><u>Ашгийн төлөвлөгөө давуулсан:</u><br>"Хэсэгчилсэн инженерийн хангамжийн газар" ОНӨААТҮГ<br>*Зорилт-0 төгрөг*<br>*Гүйцэтгэл-8,971.5 мян.төг*<br>"Багачууд хүнс" ОНӨААТҮГ<br>*Зорилт-76,906.8 мян.төг*<br>*Гүйцэтгэл-99,701.9 мян.төг* | |
| 6. | Арга хэмжээ: 2.1.3<br>Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот | - | -Хуулийн этгээдийн тоо | Орон нутгийн өмчит 15 аж ахуйн | ОНӨААТҮГ-ын 15 газрын захиралтай 2024 оны "Онцгой | ТӨБЗГ-ын 2022 оны 184 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлдвэрийн газрын захиралтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах | | - Баталгаажсан байх | тооцоотой үйлдвэрийн газартай гэрээ байгуулсан. | нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-г байгуулна. | байгуулах, дүгнэх журам"-ын дагуу нийслэлийн өмчит 15 үйлдвэрийн газрын захиралтай нэг жилийн хугацаатай 2024 оны "Онцгой нөхцөлтэй хөдөлмөрийн гэрээ"-г байгуулан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаар гэрээг баталгаажуулсан.<br>*1.ОСНААУГ ОНӨААТҮГ*<br>*2.УСУГ ОНӨААТҮГ*<br>*3.Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ*<br>*4.Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ*<br>*5.Геодези усны барилга байгууламж ОНӨААТҮГ*<br>*6.Хэсэгчилсэн инженерийн хангамжийн газар ОНӨААТҮГ*<br>*7.Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ*<br>*8. Хот тохижилтын газар ОНӨААТҮГ*<br>*9.Өсвөр үе хүнс" ОНӨААТҮГ*<br>*10.Хүнс хангамж ОНӨААТҮГ*<br>*11.Багачууд хүнс ОНӨААТҮГ*<br>*12.Асгат ОНӨААТҮГ*<br>*13.Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ*<br>*14."Хот төлөвлөлт судалгааны институт" ОНӨААТҮГ*<br>*15."Гэрлэх ёслолын ордон" ОНӨААТҮГ*<br>*16.Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ*<br>*17.Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ*<br>*18.Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ*<br>*19. Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ*<br>*20. Зоригч тээвэр тав ОНӨААТҮГ* | |
| Зорилт 2. Нийслэлийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих зорилт (НИТХТ-ийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан журам) | | | | | | | |
| 7. | Арга хэмжээ: 2.2.1<br>УЗ, ТУЗ-ийн гишүүдийг томилох чөлөөлөх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад санал боловсруулан, шийдвэрлүүлэх | - | Тогтоолын төсөл боловсруулсан байх | НИТХ-ын 2023 оны 24, 53, 68, 71, 83, 103, 108 дугаар тогтоолуудаар УЗ, ТУЗ-ын гишүүдийн томилж, чөлөөлсөн. | УЗ, ТУЗ-ийн гишүүдээс ирүүлсэн саналыг үндэслэн УЗ, ТУЗ-ийн гишүүдийг томилж, чөлөөлөх асуудлыг НИТХ-д өргөн барьж шийдвэрлүүлнэ. | Нийслэлийн өмчийн харилцааны газрын цахим хуудсанд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 54 дүгээр тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журам", "Нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн Удирдах зөвлөлийн ажиллах журам"-ыг https://www.umch.ub.gov.mn/transparencies/3/1. гишүүдийн мэдээллийг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | *https://www.umch.ub.gov.mn/storage/tranparency-values/-May2023/RLtfSIYLPjiPryotLVP2.pdf* нээлттэй байршуулж, “ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган мэдээллийг Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Авлигатай тэмцэх газар, НЗДТГ-т хүргүүлэн ажилласан.<br>Нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Удирдах зөвлөл, Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг өөрчлөх тухай НИТХТ-ын тогтоолын төсөл боловсруулан батлуулсан. Үүнд:<br>- *НИТХ-ын 2024 оны 22 дугаар тогтоолоор 20 хуулийн этгээдийн 20 гишүүнийг чөлөөлөх,*<br>- *НИТХ-ын 2024 оны 23 дугаар тогтоолоор 16 хуулийн этгээдийн 38 гишүүнийг томилох,*<br>- *НИТХ-ын 2024 оны 46 дугаар тогтоолоор 3 хуулийн этгээдийн 6 гишүүнийг чөлөөлж, 2 гишүүн томилох,*<br>- *НИТХ-ын 2024 оны 81 дүгээр тогтоолоор 10 хуулийн этгээдийн 10 гишүүний чөлөөлөх,*<br>- *НИТХ-ын 2024 оны 83 дугаар тогтоолоор 1 хуулийн этгээдийн 5 гишүүдийг чөлөөлж, 6 гишүүд томилох,*<br>- *НИТХ-ын 2024 оны 84 дүгээр тогтоолоор 1 хуулийн этгээдийн 5 гишүүнийг томилох,*<br>- *НИТХ-ын 2024 оны 101 дүгээр тогтоолоор 20 хуулийн этгээдийн 51 гишүүдийг чөлөөлөх,*<br>- *НИТХ-ийн 2024 оны 102 дугаар тогтоолоор 12 хуулийн этгээдийн 12 гишүүнийг томилох,*<br>- *НИТХ-ийн 2024 оны 118 дугаар тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 гишүүнийг чөлөөлж, 4 гишүүн томилох,*<br>- *НЗД-ын 2024 оны 01/6612 дугаар албан бичгээр нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой 18 хуулийн этгээдийн УЗ болон ТУЗ-ний гишүүдийг чөлөөлж, томилох тогтоолын төсөл боловсруулан өргөн барьсан.* | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөн НИТХ-ын 2024 оны 64 дүгээр тогтоолоор Хишиг-Уул ХК-ийн итгэмжлэгдсэн 1 төлөөлөгчийг томилсон болно. | |
| 8. | Арга хэмжээ: 2.2.2<br>УЗ, ТУЗ-ийн гишүүдэд нийслэлд холбогдох мэргэжлийн байгууллагаас төлөөлөл зайлшгүй оруулах | - | Нийслэлээс төлөөлөл хэрэгжүүлж байгаа гишүүдийн тоо | Нийслэлийн өмчит 21 хуулийн этгээд, нийслэлийн өмчийн оролцоотой 5 компани нийт 26 хуулийн этгээдийн УЗ, ТУЗ-д нийслэлээс 58 гишүүн байна. | Нийслэлийн мэргэжлийн байгууллагаас УЗ, ТУЗ-ийн гишүүнээр нэр дэвшүүлэн ажиллуулсан байна. | НИТХТ-ийн 2014 оны 54 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан журмын дагуу 2024 онд нийт НИТХ-ын 9 тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөл, Удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, томилох санал саналыг өргөн барьж шийдвэрлүүлсэн. Сүүлийн байдлаар НИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн ээлжит бус II чуулганаар нийслэлийн өмчит хуулийн этгээд болон өмчийн оролцоотой компани нийт 31 хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөл, Удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, томилсон. Нийслэлийн дээд шатны байгууллага болон холбогдох мэргэжлийн байгууллагаас нийт 142 гишүүний нэрсийг өргөн барьсан. | 100% |
| 9. | Арга хэмжээ: 2.2.2<br>Нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн тооцоог гаргаж, санал боловсруулан шийдвэрлүүлэх | - | - Ногдол ашгийн мөнгөн дүн<br>- Хуулийн этгээдийн тоо | 2023 онд нийслэлийн төсөвт 800.8 сая төгрөгийн ногдол ашиг төвлөрүүлсэн. | 2024 онд нийслэлийн төсөвт 1,120.0 сая төгрөгийг төвлөрүүлэх ногдол ашгийг төвлөрүүлэх тогтоолын төсөл өргөн барьж шийдвэрлүүлнэ.<br><br>Захирамжлахын баримтын дагуу ногдол ашгийг төвлөрүүлэх ажлыг зохион байгуулсан байна. | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын 2023 оны санхүүгийн тайлангийн цэвэр ашгаас нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хувь хэмжээг тогтоон тогтоолын төсөл, танилцуулгыг НӨХГ-ын 2024.06.03-ны өдрийн 2/1030 тоот албан бичгээр өргөн барьж НИТХ-ын 2024.07.24-ний өдрийн 97 дугаар тогтоолоор 2024 онд нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хувь, хэмжээг батлуулсан. Нийслэлийн төсөвт нийт 6 ОНӨААТҮГ-ын 1,340,522.20 мянган төгрөгийг төвлөрүүлэх тогтоолын хэрэгжилтэд хяналт тавин хэрэгжилтийг бүрэн хханган ажилласан. Үүнд:<br>1. *Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ- 608,040.39 мянган төгрөг,*<br>2. *Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ – 2,422.31 мянган төгрөг,*<br>3. *Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ – 679.09 мянган төгрөг,*<br>4. *Хүнс хангамж төв ОНӨААТҮГ – 67,712.76 мянган төгрөг,* | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 5. *Багачууд хүнс ОНӨААТҮГ – 26,919.52 мянган төгрөг,*<br>6. *Асгат ОНӨААТҮГ – 53,470.50 мянган төгрөг,*<br>7. *Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ - 312,834.37 мянган төгрөг,*<br>8. *Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ- 124,992.80 мянган төгрөг,*<br>9. *Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ – 143,450.46 мянган төгрөг* | |
| Зорилт 3. Нийслэлийн төсөвт байгууллагуудын удирдлагатай "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний хэрэгжилтийг дүгнэх (НИТХТ-ийн 2014 оны 55 дугаар тогтоол) | | | | | | | |
| 10 | Арга хэмжээ: 2.3.1 Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 2023 оны биелэлтийг дүгнэх ажлыг зохион байгуулах | 30.0 | - Гэрээ дүгнүүлсэн хуулийн этгээдийн тоо<br>- Үнэлэгдсэн байдал | Нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой байгууллагуу даас түүвэрчилсэн байдлаар 76 байгууллагын гэрээг дүгнэсэн. "Бүрэн хангалттай"-35 "Хангалттай"-41 | Газрын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулагдан удирдамж, ажил дүгнэх үзүүлэлтийг баталсан байна.<br><br>Төлөвлөсөн хуваарийн дагуу гэрээ дүгнэн дүнгийн нэгтгэл, илтгэх хуудсыг боловсруулсан байна.<br><br>Гэрээний дүгнэлтийг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлнэ. | Газрын даргын 2024 оны А/90 дүгээр тушаалаар 168 байгууллагын удирдлагатай байгуулсан "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний 2023 оны биелэлтийг дүгнэх ажлыг хэсгийн байгуулсан. "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний биелэлтийг байгууллагын санхүүгийн аудит хийсэн тайлан, хөрөнгийн хөдөлгөөний шийдвэр, хэрэгжилт, хөрөнгийн тооллогын дүн, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлын тайлан, түүнд туссан хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, хяналт тавьсан байдал, газар эзэмшлийн гэрээ, сунгасан байдал, барилга байгууламжийн хувийн хэргийн баяжилт зэрэг баримтуудыг ашиглан дүгнэсэн. Ажлын хэсгийн тайлангаар нийт 168 байгууллагаас 83 байгууллага "Бүрэн хангалттай", 65 байгууллага "Хангалттай", 16 байгууллага "Ажил сайжруулах", 3 байгууллага "Хангалтгүй" үнэлэгдсэн, 1 байгууллага дүгнэгдээгүй байна.<br>Ажил сайжруулах байгууллагууд:<br>- *Ерөнхий боловсролын 1, 10, 31, 59, 127, 187 дугаар сургуулиуд,*<br>- *СХД-ийн 105 дугаар цэцэрлэг,*<br>- *"Тонэ" ӨЭМТ, "Энхт ачит" ӨЭМТ, "Чин хүслэн" ӨЭМТ, "Үндрах-Ирээдүй" ӨЭМТ,*<br>- *Гачуурт тосгоны Засаг даргын Тамгын газар,*<br>- *"Хан-Уул Яармаг" ОНӨААТҮГ,*<br>- *БЗД-ийн Соёлын ордон,*<br>Хангалтгүй үнэлэгдсэн байгууллагууд: | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - *БГД-ийн 96 дугаар цэцэрлэг,*<br>- *"Ангирмаа" ӨЭМТ,*<br>- *ХУД-ийн Гэр бүл, хүүхэд хөгжлийн хэлтэс,*<br>Дүгнэлтэд хамрагдаагүй байгууллага:<br>- *СБД-ийн "Бага хандгайт" ОНӨААТҮГ.* | |
| 11 | Арга хэмжээ: 2.3.2 НИТХТ-ын 2014 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г шинэчлэн байгуулах | - | - Хуулийн этгээдийн тоо<br>- Гэрээний тоо | Нийслэл, дүүргийн нийт 28 газрын удирдлагатай "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г шинэчлэн байгуулсан. | Шинээр байгуулагдсан болон удирдлага солигдсон тохиолдолд гэрээг тухай бүр шинэчлэн байгуулна. | Нийслэлийн өмчийн бүрэн бүтэн байдлыг хангах, хөрөнгийн хөдөлгөөний зохион журмын дагуу бүртгэлд тусгах, хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой гарсан тогтоол шийдвэр, захирамж, тушаалын шийдвэрийг хэрэгжүүлэх, өөрийн байгууллагын балансt байгаа хөрөнгийг ашиглалтыг сайжруулах зорилгоор НИТХТ-ийн 2014 оны 55 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу нийслэлийн өмчит төсөвт байгууллага болон ОНӨТҮГ-тай "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ" байгуулан ажиллаж байна. Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 5.2-т заасны дагуу өмч эзэмшигч байгууллагын удирдлага өөрчлөгдсөн тохиолдол тухай бүр гэрээг шинэчлэн байгуулахаар туссаны дагуу 2024 онд нийт 771 удирдлагатай гэрээ байгуулсан. Үүнд:<br>- *Баянзүрх дүүргийн 150 байгууллага*<br>- *Сүхбаатар дүүргийн 95 байгууллага*<br>- *Чингэлтэй дүүргийн 107 байгууллага*<br>- *Баянгол дүүргийн 96 байгууллага*<br>- *Сонгинохайрхан дүүргийн 143 байгууллага*<br>- *Хан-Уул дүүргийн дүүргийн 100 байгууллага* | 100% |
| Зорилт 4. Нийслэлийн өмчийн байр талбай, эд хөрөнгийн ашиглалтыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх зорилт (НИТХТ-ийн 2014 оны 65 дугаар тогтоол) | | | | | | | |
| 12 | Арга хэмжээ: 2.4.1 Нийслэлийн өмчийн байр талбайг иргэн, аж ахуй нэгжид түрээслүүлэх, түрээслэх байр талбайн сонгон шалгаруулалт зохион байгуулах | - | - Түрээсийн гэрээний тоо<br>- Гэрээний хэрэгжилт<br>- Түрээсийн гэрээний дэлгэрэнгүй судалгааг хөтлөх | Нийт 230 түрээсийн гэрээг ААНБ, иргэнтэй байгуулснаас хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа 128 түрээсийн гэрээ байна. Дам | Түрээсийн гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсгийн тушаал батална.<br><br>Гэрээний хэрэгжилтийг харгалзан иргэн, аж ахуйн нэгжтэй | 1.Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, хяналт шалгалт хийх, гэрээний биелэлтийг дүгнэх<br><br>Газрын даргын 2024 оны №01 удирдамжийн дагуу ЧД, СБД, БХД, ХУД, СХД, НД-ийн нийт 80 байгууллагад шалгалт хийхэд түрээсийн төлбөр дутуу төвлөрүүлсэн, зөвшөөрөлгүй үүрэн холбооны төхөөрөмж, банкны АТМ байрлуулсан, хувийн хөрөнгөөр өргөтгөл барьсан зэрэг зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүлэн ажилласан. Үүнд: | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | түрээсийн гэрээ – 55, Шууд түрээсийн гэрээ – 8, 2023-2024 онд сургуулийн "Үдийн хоол" хэрэгжүүлэгч байгууллагын гэрээ - 65 | түрээсийн гэрээг сунгасан байна.<br><br>Сонгон шалгаруулалт зохион байгуулах болон оролцох | - *14-н байр, талбайд түрээсийн гэрээ байгуулаагүй,*<br>- *7 байгууллага түрээсийн үйл ажиллагаа явуулаагүй (СБД-ийн ЗДТГ-ийн Худалдаа хөгжлийн банк, В.Мөнхдалай цайны газар, СБД ЭМТ-ийн сувиллын цайны газар Цолмон маргад трейд ХХК, Тод онош ХХК, Сэрж мандах ХХК кофе шоп, ЧД Нандин гурван эрдэнэ ХХК цэцэрлэг, ЧДЭМТ Сэнгэ дөш өвчтөний гал тогоо),*<br>- *СБД-ийн 17-р сургуулийн захирал нь түрээсийн цайны газартай нэмэлт гэрээ байгуулсан,*<br>- *Хүрээ амаржих газрын цайны газар 2023 онд түрээсийн гэрээ байгуулах хүсэлтийг хүргүүлсэн боловч байгуулаагүй, өвчтөний цайны газрын барилгыг гадагшаа хаалга гаргасан*<br>- *СБД, "Нүхэн гарц"-д үйл ажиллагаа явуулж байгаа 20 иргэний өргөдлийн дагуу түрээслэгчдийн хүлээн авч уулзалт зохион байгуулан, дүүргийн ЗДТГ-т нийслэлийн өмчийн байгууламжийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, түрээсийн гэрээ байгуулан ажиллахыг мэдэгдсэн. СБД-ийн ЗДТГ, түрээслэгчдийн өргөдлийг дагуу 20 түрээсийн гэрээ шинэчлэн байгуулсан.*<br>- *Хуучин Аминжаргалан ӨЭМТ-ийн барилгыг иргэн Б.Ганцогт, БГД-ийн ЗДТГ 2023. 09.17-ны өдөр 203 дугаартай түрээсийн гэрээ байгуулж "Чин гэгээн өргөө" ӨЭМТ-д ашиглуулсан зөрчлийг арилгахаар эмнэлгийн удирдлагатай уулзалт зохион байгуулж цаашид НӨХГ-тай гэрээ байгуулахыг мэдэгдсэн. Барилгын ашиглалтын асуудлаар ИХАШШ-д нэхэмжлэл гарган хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна. Чин гэрээ өрхийн эмнэлэг, БГД-ийн ЗДТГ-тай 2024.10.01-ний өдөр түрээсийн гэрээ байгуулан ажиллаж байна.* | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - *НСТӨ-ний “Г” корпуст байрлах иргэд, хуулийн этгээдийн 34 түрээсийн байр, талбайг газар дээр нь шалган судалгааг гарган. Нийслэлийн 2024 оны төсөвт НСТӨ-ний түрээсийн орлогын төлөвлөгөө батлагдсан тул 2025 оноос шууд түрээсийн гэрээ байгуулахаар болсон.*<br>- *БГД-ийн “Монгол Шуудан” ХК-ийн 24 дүгээр салбар байрны түрээслэгч Тэмүүжин групп майнинг ХХК нь байр, талбайг дамжуулан түрээсэлсэн зөрчлийг илрүүлж иргэд, аж ахуйн нэгжтэй шууд гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлэн, уулзалтыг зохион байгуулан сарын төлбөр 300.0-350.0 мянган төгрөгөөр тооцон түрээсийн гэрээ байгуулсан.*<br><br>2.НИТХТ-ийн 2014 оны 65 дугаар тогтоолоор баталсан ”Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ын дагуу нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх үйл ажиллагаа зохион байгуулан 2024 онд түрээсийн гуравласан гэрээ 252, шууд гэрээ 37, сургуулийн "Үдийн хоол” хэрэгжүүлэгчийн гэрээ 23, нийт 312 түрээсийн гэрээг хянан баталгаажуулж, дугаар олгон бүртгэсэн. Жил бүр түрээсийн гэрээг дүгнэж гэрээний хугацааг сунгах эсэх, өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг тохиролцон тэмдэглэл үйлдэн баталгаажуулж байна. Түрээсийн гэрээний төлбөрийг 2024 оны 1-11-р сарыг дуустал дансны хуулгатай тулгаж баталгаажуулсан.<br>3.Нийслэлийн өмчийн байр талбайн ашиглалтыг сайжруулах, зах зээлийн үнэтэй уялдуулан түрээслүүлж нийслэлийн өмчийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор түрээслэгч иргэд, аж ахуйн нэгжүүдтэй уулзалтад зохион байгуулан хэлэлцээр хийж 2024 оноос 1мкв талбайн үнийг нэмэгдүүлснээр түрээсийн орлого өмнө оноос 637.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 4.НИТХТ-ийн 2014 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн түрээслэгчийг сонгон шалгаруулах журам”-нд заасны дагуу нийслэлийн өмчийн эд хөрөнгийн түрээслэгчийн сонгон шалгаруулах зарыг НӨХГ-ын болон түрээслүүлэгч байгууллагын цахим хуудас, өдөр тутмын сонинд зарыг байршуулж, газрын даргын тушаалаар сонгон шалгаруулах комиссыг байгуулан иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн материалыг шалгаруулж ажилласан. Үүнд:<br><br>1.НӨХГ-т зохион байгуулсан сонгон шалгаруулалт(40 мкв дээш талбайд)<br>- *ХУД, Усан спорт сургалтын төв 65.9 мкв талбай*<br>- *БГД, ЭМТ-ийн цайны газрын 87 мкв талбай /хүчингүй болсон/*<br>- *БЗД, Улиастай автобусны эцсийн буудлын барилгын 135 мкв талбай,*<br>- *СБД, Цагдаагийн газрын цайны газрын 137 мкв талбай*<br>- *ХУД, нийслэлийн төр захиргааны байр буюу Шинэ Хангарди цогцолборт кофе шоп, ресторанcы талбай,*<br>- *БЗД, Сансар зочид буудлын дэргэдэх НӨХГ-ын 35.6 мкв талбай,*<br>- *ЧД, 18-р хорооны ӨЭМТ-ийн хуучин байрны конторын 150 мкв талбай,*<br>- *СХД, ЗДТГ-ын цайны газрын 207,63 мкв талбай,*<br>- *СХД-ийн 11 дүгээр сургуулийн цайны газрын талбай,*<br>- *СХД, 18-р хороо, 71-р сургуулийн цайны газрын 68мкв талбай,*<br>- *СХД, 16-р хороо, “Өнөр” цогцолбор сургуулийн цайны газрын 97.5м2 талбай,*<br>- *НХААГ-ын балансt бүртгэлтэй БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага КОЙКА-ийн буцалтгүй тусламжаар баригдсан БЗД, 20-р хороо, Хар ус тохой, Гачууртын зам* | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | *дагуу байрлах "Жимс, жимсгэнэ тариалан эрхлэгчдийн сургалт, үйлдвэрлэлийн төв"-ийн байгууламжийг үйлдвэрлэлийн талбай,*<br>- *БЗД-ийн 48 дугаар сургуулийн цайны газрын талбай*<br><br>2.Түрээслүүлэгч байгууллагаас зохион байгуулсан сонгон шалгаруулалтад гишүүнээр оролцсон (40 мкв доош талбайд):<br>- *БГД, Биеийн тамир спорт хорооны буфетны 25 мкв талбай,*<br>- *БГН, ЭМТ-ийн цайны газрын 36.2 мкв талбай,*<br>- *СХД, ЭМТ-ийн кофе шопын 30 мкв талбай,*<br>- *ХУД, УССТ-ийн үйлчилгээний талбай,*<br>- *БЗД, Нийслэлийн хүүхдийн сэргээн засах "Бяцхан тэмүүлэл төв"-ийн буфетийн 23 мкв талбай*<br>- *БХД, ЗДТГ -т байрлах эмийн сангийн 12 мкв талбай,*<br>- *БХД, ЗДТГ-т байрлах сургалтын төвийн 24 мкв талбай*<br>- *БХД, ЖДҮДТ-ийн ажлын байрны зориулалтын 6-н талбай (бойжигч газраас ирүүлсэн 1 саналыг дэмжсэн)*<br>- *Нийслэлийн Өргөө амаржих газрын кофе шопийн 6мкв, эмийн сангийн 22 мкв талбай* | |
| 13 | Арга хэмжээ: 2.4.2<br>Нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн санхүүгийн баланст бүртгэлтэй эд хөрөнгийг нийслэлийн төсөвт байгууллагуудад ашиглалтын гэрээгээр ашиглуулах ажлыг зохион байгуулах | - | - Өмч ашиглалтын гэрээний тоо<br>- Гэрээний хэрэгжилт | 2023 онд 6 өмч ашиглалтын гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангаН ажилласан байна. | Нийслэлийн төсөвт байгууллагын хүсэлтийг үндэслэн нийслэлийн өмчийн эд хөрөнгийг өмч ашиглалтын гэрээгээр ашиглуулсан байна. Гэрээний хэрэгжилтийг дүгнэж ажилласан байна. | Нийслэлийн Өмчийн харилцааны газрын санхүүгийн баланст бүртгэлтэй 4 "Явуулын ажлын байр"-ыг төсөвт байгууллагын албан хүсэлтийг үндэслэн ашиглалтын гэрээгээр, үнэ төлбөргүй ашиглуулж байна. Үүнд:<br>- *Нийслэлийн Мал эмнэлгийн газар – 2 явуулын ажлын байр,*<br>- *НД-ийн ЗДТГ– 1 явуулын ажлын байр,*<br>- *БГД-ийн Зооноз өвчин судлалын төв – 1* | 100% |
| Зорилт 5. Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн хөдөлгөөн түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах, хөрөнгийн хөдөлгөөнд хяналт тавих зорилт (НИТХТ-ийн 2014 оны 66 дугаар тогтоол) | | | | | | | |
| 14 | Арга хэмжээ: 2.5.1 | - | | НЗД-ын 2023 оны | Шинээр бий болсон эд хөрөнгийг | Нийслэл Засаг даргын 2024 оны захирамжийн дагуу нийслэлийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалт, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Нийслэлийн Засаг даргын хөрөнгө оруулалттай холбоотой 2024 оны хүлээн авсан захирамжуудыг үндэслэн төсөл арга хэмжээг хөрөнгийн эх үүсвэрээр ангилан, судалгааг гаргах | | Төсөл, арга хэмжээний тоо, мөнгөн дүн | захирамжаар нийслэл, орон нутгийн хөрөнгө оруулалт, замын сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжих төсөл арга хэмжээний судалгаа: *НТХО-ын 376,189.7 сая төг. 301 ажил, ЗСХ 85,233.0 сая төг. 191 ажил, ОНХС 24,026.9 сая төг. 151 ажил,*<br>*- УТХО-ын 287,742.1 сая төг. 136 ажил/* | бүртгэн мэдээллийг судалгаанд нэгтгэсэн байна. | санхүүжилтээр 277 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийн эх үүсвэрээр ангилан, судалгааг гаргасан.<br>Замын хөгжлийн сан, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, Улсын төсвийн хөрөнгө оруулалт, Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлж хэрэгжүүлсэн 277 төсөл арга хэмжээний судалгааг гаргасан. Үүнд:<br>*- Нийслэлийн замын хөгжлийн сан - 7,509.1 сая.төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 ажил,*<br>*- Нийслэлийн орон нутгийн хөрөнгө оруулалт - 246.1 сая төгрөгийн өртөг бүхий 9 ажил,*<br>*- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт - 679.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 23 ажил,*<br>*- Улсын төсвийн хөрөнгө оруулалт - 3,232.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 123 ажил,*<br>*- Азийн хөгжлийн банкны санхүүжилт - 463.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 13 ажил,*<br>*- Байгууллагын хөрөнгө - 338.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 27 ажил;*<br>*- Хандив - 58.3 сая төгрөгийн өртөг бүхий 3 ажил;*<br>*- ДТХО-аар 1,606.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий 76 ажил* | |
| 15 | Арга хэмжээ: 2.5.2<br>Төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд баригдаж ашиглалтад орсон барилга байгууламж, бий болсон тээврийн хэрэгсэл, тохижилтын ажлуудыг нийслэлийн өмчид буюу нийслэлийн өмчит төсөвт байгууллагын бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах, | - | - Бүртгэсэн хөрөнгийн дүн, сая.төг | 343,882.83 сая төг. барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, тохижилтын ажлуудыг нийслэлийн өмчид бүртгэсэн. | Нийт 212,657.3 сая төгрөгийн өртөг бүхий шинээр бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгах ажлыг хийж гүйцэтгэнэ. | 1.Төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд баригдаж ашиглалтад орсон барилга байгууламж, худалдаж авсан тээврийн хэрэгсэл, тохижилтын нийт 106,500.24 сая төгрөгийн 193 төсөл арга хэмжээ бүртгэсэн байна. Хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр ангилан харвал:<br>*- Нийслэлийн замын хөгжлийн сан – 649.3 сая.төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 ажил,*<br>*- Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан – 10,325.0.1 сая төгрөгийн өртөг бүхий 24 ажил,*<br>*- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт – 53,843.50 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 52 ажил,*<br>*- ДТХО - 4,610.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий 21 ажил,* | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - *Хот тохижилтын хөрөнгө - 851.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 8 ажил;*<br>- *Улсын төсвийн хөрөнгө оруулалт – 26,496,78 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 75 ажил,*<br>- *ГХУССан - 33 сая төгрөгийн өртөг бүхий 2 ажил;*<br>- *Азийн хөгжлийн банкны санхүүжилт – 9,690.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 5 ажил,*<br><br>2.Улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр бий болсон барилга байгууламж хүлээн авах дараах ажлын хэсэгт орж ажилласан. Үүнд:<br>- *Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон өөрөө буулгагч 12 ширхэг машин,*<br>- *Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын Сонгинохайрхан дүүрэг, 17 дугаар хороо, барилга худалдан авах НХААГ/20240102241 дугаартай ажлыг "Иргэн О.Оргил" нийлүүлэх тул сургуулийн барилга,*<br>- *Нийслэлийн Засаг даргын 2023 оны эрх шилжүүлэх тухай А/1311 дугаар захирамжаар "Хот, нийтийн аж ахуйн ажил үйлчилгээнд нэн шаардлагатай тусгай зориулалтын машин механизм" / Өөрөө буулгагч ачааны машин 12/ ширхэг нийлүүлэхийн дагуу "АОДЭ" ХХК -аас нийлүүлсэн HOWO маркийн өөрөө буулгагч машин механизмыг Сэлэнгэ аймгийн "Тохилог хараа" ОНӨААТҮГ-Т 1 ширхэг, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газарт- 1ш, "Ус сувгийн удирдах газарт-3 ш, "Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-Т 3 ш, "Геодези, усны барилга байгууламжийн газар- 3 ш, "Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газарт -1ш/ нийт 12 машин механизмыг автомашин*<br>- *Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1117 дугаар захирамжаар Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа "Нийтийн* | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | *тээврийн автобус (Улаанбаатар)" төсөл, арга хэмжээний хүрээнд байгуулагдсан НЗДТГ/202310014 дугаартай "Нийтийн тээврийн автобус нийлүүлэх гэрээ", НЗДТГ/202310014-02 дугаартай "Нийтийн тээврийн автобус нийлүүлэх нэмэлт гэрээ"-нд заасан нийтийн тээврийн зориулалттай, их багтаамжийн 31 (гучин нэг) автобуснаас эхний ээлжид 21 (хорин нэг), 2024 оны 09 дүгээр сарын 26-наас 28-ний өдрүүдэд үлдсэн 10 (арав) автобусыг 10 дугаар сарын 07-ноос 10-ний өдрүүдэд тус тус холбогдох техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу техникийн урьдчилсан үзлэг хийж, нийт 31 (гучин нэг) угсраа автобусыг "Юутонг бус" ХХК-иас хүлээн авах ажлыг зохион байгуулсан.*<br>- *Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1045 дугаар захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа "Хотын аж ахуйн ажил үйлчилгээнд нэн шаардлагатай тусгай зориулалтын машин механизм" (Улаанбаатар)-ыг гэрээ болон техникийн тодорхойлолтын урьдчилсан үзлэг хийж нийт 33 техникийг хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүн*<br>- *Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2024 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэгт ажиллан Европын холбооны Азийн хөрөнгө оруулалтын бүсийн буцалтгүй тусламж, Европын сэргээн босголт хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр авсан нийт 10ш н тусгай зориулалтын машин, тоног төхөөрөмж нийлүүлэгч компаниас гэрээнд заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу хүлээн авсан.* | |
| 16 | Арга хэмжээ: 2.5.3 Хандив бэлэглэл, буцалтгүй тусламж, зээл, төсөл хөтөлбөрөөр бий болсон эд хөрөнгийг | - | - Бүртгэсэн хөрөнгийн дүн, сая.төг<br>- ҮХХХК-ын хурлын шийдвэр | Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хандив тусламж, төсөл хөтөлбөрийн хүрээнд шинээр бий болсон | Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн ирүүлсэн хүсэлтийн дагуу бүртгэлд | Тайлант хугацаанд улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, гадаад, дотоодын зээл, буцалтгүй тусламж, хандив бэлэглэлийн хөрөнгөөр шинээр бий | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | холбогдох журмын дагуу нийслэлийн өмчид бүртгэх ажлыг зохион байгуулах | | | 30,659.8 сая төг. хөдлөх хөрөнгийг ҮХХХК-ын хурлаар шийдвэрлүүлсэн. | тусгах арга хэмжээг авч ажиллана.<br>ҮХХХК-ын хурлаар хэлэлцүүлэн, газрын даргын тушаалаар баталгаажуулсан байна. | болсон нийт 451,526.7 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:<br>1. *Барилга байгууламж 151 нэрийн 187,344.2 сая төгрөг,*<br>*2. Тээврийн хэрэгсэл 212,683.4 сая төгрөгийн үнэ бүхий 784 тээврийн хэрэгсэл,*<br>*3.Шинээр бий болсон эд хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авах тухай албан бичиг хүргүүлж бүртгэсэн хөрөнгө 41,150.8 сая төгрөг,*<br>*4.ҮХХХК-ын хурлаар бүртгэсэн хөрөнгө 3,211.0 сая төгрөг,*<br>*3. Бүртгэсэн тушаал ирүүлсэн байгууллагуудын хөрөнгө 7,137.2 төгрөг* | |
| 17 | Арга хэмжээ: 2.5.4<br>Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн балансt бүртгэлтэй ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг акталж, данснаас хасах | - | -Акталсан барилгын тоо<br>-Мөнгөн дүн сая.төг | Нийслэлийн өмчийн 14 хуулийн этгээдийн 361.7 сая төг. бүртгэлийн үнэ бүхий 33 барилга байгууламжийг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хассан | Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн ирүүлсэн хүсэлтийн дагуу тогтоол, захирамжийн төсөл боловсруулан, батлуулж холбогдох арга хэмжээг авч ажиллана. | НИТХТ-ийн 66 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам"-д заасны дагуу нийслэлийн өмчийн 30 хуулийн этгээдийн балансt бүртгэлтэй **3,066.3** сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 36 барилга байгууламжийг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах асуудлыг НИТХ-д өргөн барьж шийдвэрлүүлсэн. **Үүнд:**<br>- *2024 оны 14 дүгээр тогтоолоор ХУД-ийн ЗДТГ-ын 827.0 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хуучин барилга,*<br>- *2024 оны 51 дүгээр тогтоолоор ОСНААУГ-н ОНӨААТҮГ-ын 91.0 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 3 барилга, ЧД-ийн ЖДҮДТ ТҮГ-ын 64.5 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилга,*<br>- *2024 оны 54 дүгээр тогтоолоор УСУГ ОНӨААТҮГ-ын 37.2 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий гүний худгийн 2 барилга, ус түгээх 6 байр,*<br>- *2024 оны 57 дугаар тогтоолоор нийт 425.2 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий БХД-ийн ГБХЗХГ-ын хуучин барилга,* | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - *2024 оны 58 дугаар тогтоолоор 186.4 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 7 дугаар сургуулийн хуучин барилга,*<br>- *2024 оны 82 дугаар тогтоолоор 40.8 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий НД-ийн ЗДТГ-ын 1 дүгээр хорооны соёлын төвийн ашиглалтгүй барилга,*<br>- *2024 оны 95 дугаар тогтоолоор 275.6 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 30-р сургуулийн хуучин барилга,*<br>- *202 оны 96 дугаар тогтоолоор 1.5 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий ОСНААУГ-ын станцын барилга, цахилгааны тоног төхөөрөмж,*<br>- *2024 оны 113 дугаар тогтоолоор 5.1 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Өнөр бүл Хүүхдийн төвийн зоорийн байр,*<br>- *2024 оны 115 дугаар тогтоолоор 637.7 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 108-р цэцэрлэгийн хуучин барилга,*<br>- *2024 оны 116 дугаар тогтоолоор 289.0 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 75-р цэцэрлэгийн хуучин барилга,*<br>- *2024 оны 117 дугаар тогтоолоор 64.9 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий СХД, Гурван цүүр ӨЭМТ-ийн хуучин барилга,*<br>- *2024 оны 129 дүгээр тогтоолоор 19.3 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын 2 барилга,*<br>- *2024 оны 133 дугаар тогтоолоор 165.5 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 23-р сургуулийн спорт заалны барилга,*<br>- *2024 оны 135 дугаар тогтоолоор 251.0 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий УСУГ-ын ОНӨААТҮГ-ын 11 ширхэг ус түгээх байр*<br><br>Төрийн өмчид шилжүүлж нийслэлийн өмчөөс хасагдсан барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, эргэлтийн бус хөрөнгөд: | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - *НИХТ-ын 2024 оны 121 дүгээр тогтоол, НЗД-ын А/1257 дугаар захирамжаар НЗДТ, ННҮГ, НИТХ-ын баланст бүртгэлтэй 13,763.1 сая төгрөгийн эд хөрөнгө, үүнээс 13,430.7 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Хангарди ордны барилга, байгууламжийг Улсын дээд шүүхэд,*<br>- *НИТХ-ын 2024 оны 131 дүгээр тогтоол, НЗД-ын А/1294 дүгээр захирамжаар Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 40.5 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий халаалтын зуухыг "Монголын төмөр зам" ТӨХК-д,*<br>- *НИТХ-ын 2024 оны 132 дүгээр тогтоол, НЗД-ын А/1257 дүгээр захирамжаар НЦУГ, БГД, БЗД, СБД, СХД, ХУД, ЧД Цагдаагийн газрын нийт 2,366.7 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий тоног төхөөрөмж, тавилга, 12 тээврийн хэрэгслийг төрийн өмчид буюу Цагдаагийн Ерөнхий газрын харьяа 7 байгууллагад* | |
| 18 | Арга хэмжээ: 2.5.5 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн баланст бүртгэлтэй ашиглалтын шаардлага хангахгүй тээврийн хэрэгслийг акталж, данснаас хасах | - | - Акталсан тээврийн хэрэгслийн тоо<br>- Мөнгөн дүн сая.төг | Нийслэлийн өмчийн 2 хуулийн этгээдийн 17,390.9 сая төг.бүртгэлийн үнэ бүхий 167 тээврийн хэрэгслийг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахаар шийдвэрлүүлсэн. | Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн ирүүлсэн хүсэлтийн дагуу захирамжийн төсөл боловсруулан, батлуулж данснаас хасах арга хэмжээг зохион байгуулна. | НИТХТ-ийн 66 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам"-д заасны дагуу нийслэлийн өмчийн нийт 16,067.8 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 179 тээврийн акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах асуудлыг Нийслэлийн Засаг даргад өргөн барьж шийдвэрлүүлсэн.<br>Нийслэлийн Засаг даргын А/159 дүгээр ажлын хэсэг байгуулах тухай захирамжаар нийслэлийн өмчит болон төсөвт байгууллагуудын сэргээн засварлаж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй, техникийн комиссын дүгнэлтээр цаашид ашиглах боломжгүй нь тогтоогдсон тээврийн хэрэгслүүдийг газар дээр нь очиж үзэн, санал дүгнэлтийг боловсруулж, дээд шатны байгууллагад танилцуулсан. Тус санал дүгнэлтийг үндэслэн нийслэлийн Засаг даргын 2024 оны А/606 дугаар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 39 | Арга хэмжээ: 3.1.11 2024 оны "Тохижилт бүтээн байгуулалт"-ын жил төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний дагуу байгууллагын хэмжээнд арга хэмжээ шинээр санаачлан ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт | - | Нийслэлээс батлагдсан хуваарийн дагуу арга хэмжээнд оролцсон байна. | 1. Налайх дүүргийн Шинэ-Налайх цэцэрлэгт хүрээлэнд 2024.05.10-ны өдөр 100 ширхэг хайлаас мод, 2024.10.04-ний өдөр 11 ширхэг миндаль модыг тарих, арчлах ажилд нийт хамт олныг хамруулж ажлын тайланг тухай бүр НЗДТГ-т хүргүүлэн ажилласан.<br>2. “Хаврын их цэвэрлэгээ” нэгдсэн арга хэмжээнд Сити тауэр барилгын Ашиглалтын захиргаатай хамтран 2024.04.12-ны өдөр байгууллагын гадна орчны 50 метр хүртэлх газрын, 2024.04.13-ны өдөр Чингэлтэй дүүрэгт Баянбүрдийн тойргоос урагшаа Тусгаар тогтнолын талбайн урд үзүүр хүртэлх талбайн явган хүний замын, 2024.05.16-ны өдөр Их наяд төвийн баруун уулзвараас Энхтайвны гүүрний уулзвар хүртэлх голын урд хэсгийн хог хаягдлыг тус тус хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах ажлыг хийсэн.<br>3. Албан хаагчдын ажиллах таатай орчин бүрдүүлэх, эмх цэгц аюулгүй байдлыг хангах, харилцагчдад таатай сэтгэл төрүүлэх хүрээнд байгууллагын албан хаагчдын ажлын ширээ, сандал, компьютер, хэвлэх тоног төхөөрөмжүүдийг бүрэн шинэчилж, өрөө тасалгаандаа таримал цэцгийн булан гаргаж, агаар орчноо цэвэршүүлж, цайны хэсэг гаргах шинэ зохион байгуулалт хийх ажлыг санаачлан ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 4. Сар бүр албан хаагчид өрөө тасалгааны цэвэрлэгээ хийх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | |
| Зорилт 2. Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах ажиллах зорилтын хүрээнд | | | | | | | |
| 40 | Арга хэмжээ: 3.2.1<br>Шилэн дансны тухай хууль, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын дагуу шилэн дансны мэдээллийг nttps://shilendans.gov.mn цахим системд цаг хугацаанд нь байршуулах | - | -Мэдээ, мэдээллийг хугацаа хоцроолгүй байршуулсан байх<br>-Байршуулсан мэдээ, мэдээллийн тоо<br>-Өмнөх оны мэдээлээгүй зөрчлийг арилгасан байх | https://shilendans.gov.mn/organization/1173 цахим хуудсанд нийт 163 мэдээлэл оруулсан. | Төсөв санхүүгийн тайлан мэдээг шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцроолгүй байршуулсан байна.<br>-Төсөв, санхүүгийн ил тод байдал хангагдана. | 2024 оны 11-р сарын 30-ны өдрийн байдлаар Шилэн дансанд нийт 159 мэдээллийг бүрэн үнэн зөв, бодитой, иж бүрэн байршуулсан. Төрлөөр нь авч үзвэл:<br>- *Төсвийн гүйцэтгэлийн 84 мэдээлэл*<br>- *Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 33 мэдээлэл,*<br>- *Бусад 34 мэдээлэл* | 100% |
| 41 | Арга хэмжээ: 3.2.2<br>Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай хэмнэлттэй зарцуулж, төсвийн өр авлага үүсгэхгүй ажиллах | | Нийт орлого, төсвийн зарлага сая.төг | Орон нутгийн төсвөөс 1,727.8 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 55,7 сая төгрөг нийт 1,783.8 сая төгрөгийн санхүүжилт орж 1,165.4 сая төгрөгийг үр ашигтай зарцуулж, 618,2 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан. | Төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулсан байна. Хэмнэж ажилласан байна. | Орон нутгийн төсвөөс 2,209.69 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 262.8 сая төгрөг нийт 2,472.49 сая төгрөгийн санхүүжилт орж 876.6 сая төгрөгийг үр ашигтай зарцуулж, хэмнэлттэй ажилласан.<br>Зардлын задаргаа:<br>- *Цалин, хөлс 899,2 сая төгрөг*<br>- *НДШ 273,8 сая төгрөг*<br>- *ХАОАТ 75,8 сая төгрөг*<br>- *Байрны ашиглалт 27,6 сая төгрөг*<br>- *Хангамжийн материалын зардал 88,5 сая төгрөг*<br>- *Бусад зардалд 467,9 сая төгрөг*<br>- *Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 59,9*<br><br>Төсвийн гүйцэтгэлийн орлогын мэдээ, нийгмийн даатгалын тайланг https://portal.ndaatgal.mn сайтад 2 удаа, 10,11 дугаар сарын борлуулалтын орлогыг төлбөрийн баримтын систем | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | https://ebarimt.mn/pages/ хугацаанд нь гаргаж холбогдох газруудаар хянан баталгаажуулж, цахим мэдээллийн системд мэдээлсэн. | |
| 42 | Арга хэмжээ: 3.2.3<br>Төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь хангаж биелүүлэх | - | Нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн орлого сая.төг | Өссөн дүнгээр 6,012.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 3,018.1 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөө нь 50% хувьтай хэрэгжсэн. | Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/12 дугаар захирамжаар 2,056.0 сая төгрөгийг төсөвт хуваарийн дагуу төвлөрүүлсэн байна. | Нийслэлийн Өмчийн харилцааны газраас нийслэлийн төсвийн орлогын хуваарийн дагуу түрээсийн орлого, актлагдсан хөрөнгө борлуулсны орлого, аж ахуй нэгжийн ногдол ашгийн орлогын төлөвлөгөө 6,338.9 сая төгрөг, гүйцэтгэл өссөн дүнгээр 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар 6,679.1 сая төгрөг төвлөрүүлж биелэлт 105%-ийн хэрэгжилттэй ажилласан.<br>- *Түрээсийн төлөвлөгөө 3,068,9 сая төгрөг, биелэлт 2,772.2 сая төгрөг (96%),*<br>- *Ногдол ашгийн төлөвлөгөө 1,1200, сая төгрөг, биелэлт 2,994,9 сая төгрөг (26269%),*<br>- *Актлагдсан хөрөнгө борлуулсны орлогын төлөвлөгөө 150.0 сая төгрөг, биелэлт 262.8 сая төгрөг (175,2%),*<br>- *Өмч хувьчлалын төлөвлөгөө 2,000,0 сая төгрөг, биелэлт 699.2 сая төгрөг (34.5%).* | 100% |
| 43 | Арга хэмжээ: 3.2.4<br>Байгууллагын баланст шилжүүлсэн урт хугацаат өр төлбөрийн үндсэн болон хүүгийн төлбөрийг холбогдох байгууллагад уламжлан, шийдвэрлүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллах | - | - Мөнгөн дүн сая.төг<br>- Урт хугацаат өр төлбөр буурсан байх | 2022 оны нийслэлийн төсвөөс Ус сувгийн удирдах газрын дамжуулан зээлийн хуримтлагдсан үндсэн төлбөрт 34.3 тэрбум төгрөг, 2023 оны нийслэлийн төсвөөс 12.3 тэрбум төгрөгийг нийт 46.7 тэрбум төгрөг төлөгдөн урт хугацааны өр төлбөрийг бууруулсан. | “УСУГ”ОНӨААТҮГ-ын урт хугацааны өр төлбөр байгууллагын баланст тусгагдсан байна. Хүүгийн төлбөр барагдуулахад хяналт тавьж ажиллана. | “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын урт хугацааны 200,112.9 сая төгрөгийн зээлийн үндсэн болон хүүгийн эргэн төлөлтийн дүнг Санхүү төрийн сангийн хэлтсийн Өрийн удирдлагын тасагтай хамтран авлага, өглөгийн тооцоог үүсгэж, өгсөн чиглэлийн дагуу 2024 санхүүгийн тайланд тусган тайлагнаж байна. НӨХГ-ын 2024 оны баланст тусгагдсанаас үндсэн зээл, хүүгийн төлбөрийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас манай байгууллагад шилжүүлээгүй байна. | 100% |
| 44 | Арга хэмжээ: 3.2.5 | - | - Татан төвлөрүүлсэн | Үнэ тогтоох ажлын хэсэг | Нийслэлийн өмчит хуулийн | Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн акталж данснаас хассан тээврийн хэрэгсэл, бусад | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн акталж данснаас хассан тээврийн хэрэгсэл, бусад хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах | | хөрөнгийн дүн, сая.төг<br>-Үнэ тогтоох ажлын хэсгийг байгуулж, хөрөнгө үнэлсэн байх | байгуулагдан 2023 оны А/153 дугаар тушаалаар байгуулсан. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамжаар данснаас хассан хөрөнгийн хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 50.9 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн. | этгээдийн акталж данснаас хассан тээврийн хэрэгсэл, бусад хөрөнгийг нүд үзэн шалгаж хөрөнгө хүлээлцэх акт үйлдсэн байна.<br>Нийслэлийн төсөвт батлагдсан хуваарийн дагуу 45.0 сая төгрөгийг төвлөрүүлж ажилласан байна. | хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлэх хөрөнгийг хадгалах, худалдан борлуулах зориулалтаар ашиглахаар хуучнаар НХМХ-ын эзэмшлийн хашааг шилжүүлэн авч үйл ажиллагааг явуулж байна. Аж ахуйн хашааны шийдвэрийн талаар:<br>- *Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын аж ахуйн зориулалтаар ашиглаж байсан СХД-ийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 3946 мкв газрыг шилжүүлэн авах тухай 2024.03.19-ний өдрийн 4/475 тоот албан бичгийг хүргүүлсэн. "Газар эзэмших, ашиглах эрх олгохыг хянан шийдвэрлэх зөвлөл"-ийн 2024.03.22-ны өдрийн 10 дугаар хурлаар хэлэлцүүлэн дэмжигдэж нийслэлийн Засаг даргын 2024.05.02-ны өдрийн А/495 дугаар захирамжаар оффис, албан конторын болон аж ахуйн хашаа, агуулахын зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлсэн.*<br>- *БЗД, 11 дүгээр хороо Товчооны зам 1-03 тоотод байрлах 1351 мкв талбайтай нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын аж ахуйн зориулалтаар ашиглаж байсан Богдхан уулын тусгай хамгаалалтын газрын хязгаарлалтын бүсэд хамаарч байсан газрыг ашиглах талаар "Байгаль орчин, аялал жуулчлалын яам"-нд уламжлан шийдвэрлүүлж дэмжлэг үзүүлэх талаар" Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд 2024.03.01-ны өдрийн 4/377 тоот албан бичиг, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн Бодлого зохицуулалтын газарт 2024 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн 4/671 тоот албан бичгийг хүргүүлэн хязгаарлалтын бүсэд газар ашиглуулах зөвлөлийн хурлаар дэмжигдээд байна.* | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/606 дугаар захирамжаар Нийслэлийн өмчит болон төсөвт байгууллагуудын сэргээн засварлаж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй, техникийн комиссын дүгнэлтээр цаашид ашиглах боломжгүй нь тогтоогдсон нийт 2,447,147,488.36 (хоёр тэрбум дөрвөн зуун дөчин долоон сая нэг зуун дөчин долоон мянга дөрвөн зуун наян найман төгрөг гучин зургаан мөнгө) төгрөгийн 80 тээврийн хэрэгслийг данснаас хасахаар шийдвэрлэсэн. 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр нээлтэй дуудлага худалгааг зохин байгуулж 41 тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар худалдан борлуулж 114,0 мян төгрөг, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 32 тээврийн хэрэгслийг худалдан борлуулж 12,9 мян төгрөг төвлөрүүлсэн.<br>Нийслэлийн өмчит 217 хуулийн этгээдийн хагас болон бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогын дүн, өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлт, саналыг үндэслэн үндсэн хөрөнгө акталж данснаас хасах тухай хүсэлтийн дагуу НӨХГ-ын тушаалаар данснаас хассан хөрөнгийг татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж Актлагдсан хөрөнгө борлуулсны орлого 262,856.0 сая төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн. | |
| Зорилт 3. Байгууллагын хууль эрх зүйн чиглэлээр хийх ажлууд | | | | | | | |
| 45 | Арга хэмжээ: 3.3.1<br>Нийслэлийн өмчтэй холбоотой шүүхийн маргаанд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг даргаас олгосон итгэмжлэл болон байгууллагыг төлөөлж оролцох эрх зүйн аливаа | - | Төлөөлж оролцсон шүүхийн маргааны тоо | Нийслэлийн Засаг даргыг шүүхэд итгэмжлэлээр төлөөлж оролцсон 4 маргаанд шүүхээр эцэслэгдсэн шийдвэрлэгдсэн. | Нийслэлийн өмчтэй холбоотой шүүхийн маргаан шийдвэрлэхэд оролцсон байна. | Шүүхийн маргаанд төлөөлөн оролцох<br>1. "Бигмайнд Бюлдинг" ХХК-ийн нэхэмжлэлтэй, "Солонго" орон сууцны хорооллын гаднах цэвэр усны шугам, бохир усны гол шугамын хамтран өмчлөгчөөр тогтоолгох тухай шаардлага бүхий нэхэмжлэлтэй хэргийн 2024.04.17-ны өдөр анхан шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн ба 2024 оны 09 сарын 18-ны өдрийн давж заалдах шатны шүүх хурлаар уг шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | маргааныг шийдвэрлэхэд оролцох | | | Үүнээс 2 маргаанд төлөөлөгчөөр оролцож, 2 маргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байна. | | 2. Иргэн Г.Мөнхсайханы нэхэмжлэлтэй, Төрийн албанаас түр чөлөөлсөн тушаал гаргахгүй байгаа эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох, төрийн албанаас түр чөлөөлсөн тушаал гаргахыг даалгах шаардлага бүхий нэхэмжлэлтэй хэргийг 2024.05.27-ны өдөр анхан шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, зарим хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн шийдвэрийн биелэлтийг хэрэгжүүлэн, тушаалын төслийг бэлтгэж танилцуулан, албажуулсан.<br>3. "Материал Импекс" ХК-ийн нэхэмжлэлтэй НӨХГ-т холбогдох, 2013 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 2013/33 дугаар гэрээг хүчин төгөлдөр бус байх хэлцэлд тооцуулах, хэлцлээр шилжүүлсэн зүйлсийг буцаан гаргуулах шаардлагатай иргэний хэргийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байна.<br><br><u>НӨХГ-ын нэхэмжлэлтэй маргаанд оролцох</u><br><br>1. Нийслэлийн өмчийн харилцааны газрын нэхэмжлэлтэй "Улаанбаатар радио" ХХК -д холбогдох нийслэлийн өмчийн байр /Баруун Сэлбэ үйлчилгээний "Ж" блокийн 1226.69 м.кв талбай/ -ыг албадан чөлөөлүүлэх шаардлагатай иргэний хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаа,<br>2. Иргэн Б.Ганцоргтод холбогдох нийслэлийн өмчийн байр талбайтай холбоотой иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа | |
| 46 | Арга хэмжээ: 3.3.2 Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд дагаж мөрдөж байгаа тогтоол, дүрэм, журмуудад холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах ажлыг үе | - | Санал өгсөн хууль, дүрэм, журмын тоо | Захиргааны хэм хэмжээний 9 акт, 1 журмын төсөл, хуулийн төслүүдэд өгөх 12 саналыг дээд | Нэмэлт өөрчлөлтийн дагуу тогтоол, дүрэм, журам шинэчлэгдсэн байна. | Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд дагаж мөрдөж байгаа тогтоол, дүрэм, журмуудад 10 удаагийн холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах шаардлага байгаа эсэхийг судлан санал хүргүүлсэн. Үүнд:<br>- *Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын төсөл* | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шаттайгаар зохион байгуулах | | | шатны байгууллагад хүргүүлж ажилласан. | | - *Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн дүрэм"-ийн төсөл,*<br>- *Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавих" журам,*<br>- *Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл"-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 8 стандартын төсөл,*<br>- *Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх, нөөцийн санг ашиглах журам",*<br>- *Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам",*<br>- *Төрийн албаны тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнах журам",*<br>- *Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-ын төсөл,*<br>- *Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төсөл,*<br>- *НИТХТ-ийн 2014 оны 54, 55, 65, 66 тогтоолуудаар баталсан журмуудын төсөл* | |
| 47 | Арга хэмжээ: 3.3.3<br>Батлагдан гарсан хууль тогтоомжид нийцүүлэн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмуудыг шинэчлэн боловсруулж батлах, хэрэгжилтийг ханган ажиллах | - | Шинэчлэн баталсан дүрэм журмын тоо | Байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөх 3 журамд өөрчлөлт оруулж, 3 гэрээний загварыг шинээр боловсруулан баталж, албан хаагчдад танилцуулан, хэрэгжилтийг | Дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмууд шинэчлэгдсэн байна. | Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмуудад хууль тогтоомжид нийцээгүй зохицуулалт байгаа эсэх, тэдгээрийг шинэчлэн боловсруулах шаардлага байгаа эсэхийг судалж, өдөр тутам хэрэгжилтийг ханган, албан хаагчдад зөвлөгөө, мэдээлэл, санал өгч ажилласан. Үүнд.<br>- *Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл,*<br>- *Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журмын төсөл,*<br>- *"Нийслэлийн өмчийн харилцааны газрын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах журам"-ын төсөл,* | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хангаан ажилласан. | | - *“Нийслэлийн өмчийн харилцааны газрын хөдөлмөрийн дотоод журам”-ын төсөл* | |
| **Зорилт 4. Байгууллагын гаргасан бодлогын баримт бичиг, тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 48 | Арга хэмжээ: 3.4.1 Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт болон байгууллагын гүйцэтгэлийн тайланд тухай бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнах | - | Хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн тоо | -Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн хяналт шалгалтын 03/132, 03/2273 тоот зөвлөмжийн хэрэгжилт, байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас, бүтэн жилийн биелэлтэд 6 удаагийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан үнэлгээний журмын дагуу хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн байна. | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2, 6.3 заасан аргачлалын дагуу байгууллагын хяналтад авсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн Илтгэх хуудсаар танилцуулан, зөвлөмж хүргүүлж ажилласан. Үүнд:<br>- *Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилт 70%,*<br>- *Нийслэлийг 2023 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөө, Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ 57.5%,*<br>- *Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 40 тогтоолын 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийн хэрэгжилт 97.6%,*<br>- *Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 8 тогтоолын нэгдүгээр улирлын хэрэгжилт 91.4%,*<br>- *Нийслэлийн Засаг даргын 2024 оны 20 захирамжийн 23 заалтын хэрэгжилтийн дундаж үнэлгээ 97.9%*<br>- *Байгууллагад ирсэн өргөдөл, гомдол, хүсэлтийн шийдвэрлэлтийн улирал бүрийн тайлан 100%*<br><br>Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны биелэлт, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Өмчийн харилцааны газрын 58 төсөл арга хэмжээний гүйцэтгэлд хяналт-шинжилгээ үнэлгээ хийгдэж байна. | |
| 49 | Арга хэмжээ: 3.4.2 Хяналт шалгалтын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн мөрөөр ажил сайжруулах болон зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, ажил сайжруулах, үр дүнг тооцож ажиллах | - | -Ажил сайжруулах болон зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулсан байх<br>-Ирсэн зөвлөмжийг нийт албан хаагчдад танилцуулсан байх | Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 3 хяналт шалгалт ажлын зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлан хэрэгжилтийг ханган ажилласан. | Зөвлөмжийн дагуу ажил сайжруулах төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг НЗДТГ, холбогдох хяналтын байгууллагуудад тайлагнасан байна. | 1.Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2023 оны ажил дүгнэх тухай" А/349 дүгээр захирамжаар "Хангалттай" үнэлгээ авч ажил сайжруулах зөвлөмж ирээгүй байна.<br>2. Байгууллагын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн Нийслэлийн төрийн Аудитын газрын 1 зөвлөмжийн дагуу анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийхгүй байх, зардал тооцохгүй байх зөрчилд барьцаа чөлөөлөлтөөр ашиглагч байгууллагаас чанарын баталгааг цуцлах хүсэлт ирээгүй, бусад нолох баримтын бүрдэл дутуу байхад 10,147,5 мянган төгрөг олгосон нь төсөв хяналгүй зарцуулах үр дагавар бий болсон зөрчил арилгасан. Хэрэгжилтийг Санхүүгийн тайлангийн аудитын системд оруулсан.<br>3. Төрийн аудитын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн зөрчлүүдийг дараах байдлаар арилгаж арилгаж 2024 оны 8-р сарны 30-ны дотор Төрийн аудитын байгууллагад тайлагнасан. Үүнд:<br>- *Хөрөнгө оруулалтын орлогын ажлын гэрээний хугацаа дууссан барьцаат өглөг 14,407,0 мянган төгрөгийг төсвийн орлого дансанд төвлөрүүлээгүй зөрчлийг арилган Төрийн аудитын газрын "НТАГ.хүү" дансанд төвлөрүүлсэн.*<br>- *Түрээсийн орлогын гэрээний дүнг дутуу бүртгэгдсэн зөрчлийг арилгаж нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бүртгэн 32,170,0 мянган төгрөгийг Төрийн аудитын газрын "НТАГ.хүү" дансанд төвлөрүүлсэн.*<br>- *Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгүүлээгүй 31,181,6 мянган төгрөгийн* | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | *орлого 26,507.1 мянган төгрөгийн зардлыг нөхөн байршуулсан.*<br>- *Буянт-Ухаа-1 хорооллын 30-н айлын орон сууцны төлбөрийг оршин суугчдаас авах ажлыг зохион байгуулсан ажлын хүрээнд 2 айл бүрэн төлж бусад хэсэгчлэн төлсөн байна.* | |
| 50 | Арга хэмжээ: 3.4.3 Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг бодитой үнэлэх | - | -Үнэлгээний комисс байгуулсан байх<br>-Үнэлгээний комисс зохих журмын дагуу албан хаагчдыг үнэлсэн байх. | Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2023 оны А/146, А/467 дугаар тушаалаар үнэлгээний комисс байгуулагдсан | Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлал загварын дагуу үнэлгээний ажлыг зохион байгуулсан байна. Нийт албан хаагчдад танилцуулсан байна. | 3.Газрын даргын 2024.05.29-ний өдрийн А/93 дугаар тушаалаар байгуулсан үнэлгээний баг нэгжийн дарга, албан хаагчийн төлөвлөгөөний биелэлтийг хянаж, төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх аргачлалын дагуу үнэлгээний хуудсаар 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийг үнэлсэн. Газрын даргын 2024.12.02-ны өдрийн А/506 дугаар тушаалаар үнэлгээний баг байгуулан 2024 оны сүүлийн хагас жилийн гүйцэтгэлийг үнэлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. | 100% |
| 51 | Арга хэмжээ: 3.4.4 Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөний хэрэгжилтийг UBERP дотоод удирдлагын хяналт-шинжилгээ үнэлгээ цэс, Газрын даргын шуурхай хурлаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг дотоод удирдлагын UBERP ажлын хэсэг, үүрэг даалгавар цэсэд тухай бүр байршуулан тайлагнах хяналт тавих | - | -Нийслэлийн удирдах ажилтны зөвлөгөөн, газрын шуурхай хуралдааны тоо,<br>-Үүрэг даалгаврын тоо, биелэлтийн хувь | Нийслэлийн Засаг дарга бөгөөд УБ хотын захирагчаас өгсөн нийт 131 үүрэг даалгаврын биелэлтийг Хяналт шинжилгээ үнэлгээ дэд системд байршуулан ажилласан. | Зөвлөгөөнөөр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг 90%-аас дээш хангаж биелүүлнэ. | Нийслэлийн удирдах ажилтны шуурхай 21 удаагийн зөвлөгөөний 65 үүрэг даалгаврын хэрэгжилтийг UBERP дотоод удирдлагын хяналт-шинжилгээ үнэлгээ цэст хавсралт материалын хамт оруулан хугацаанд нь байршуулж, хяналт-дүгнэлт хийн тайлагнан ажилласан. | 100% |
| Зорилго 4. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. | | | | | | | |
| Зорилт 1. Төрийн үйлчилгээг ил тод, хурдан шуурхай, чанартай, хүртээмжтэй болгоно. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 52 | Арга хэмжээ: 4.1.1 Мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийтэд мэдээлэх боломжтой мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан ил тод нээлттэй мэдээлэх | - | - Байгууллагын цахим хуудсанд байршуулсан мэдээ, мэдээллийн тоо | Байгууллагын болон салбарын хууль тогтоомж, эрх зүйн актууд, дүрэм, журмын мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан ил тод нээлттэй байршуулсан байна. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэн мэдээ мэдээллүүдийг 7 хоног бүр шинэчлэн байршуулсан байна. | 1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг харган ажиллах хүрээнд иргэд, аж ахуйн нэгж, бусад байгууллагад байгууллагын цахим хуудсанд дараах мэдээллийг нээлттэй байршуулж байна. Үүнд:<br>- *Байгууллагын танилцуулга, хэлтсийн чиг үүрэг, утасны жагсаалт* https://www.umch.ub.gov.mn/role/index/mn ,<br>- *Цаг үеийн мэдээ мэдээлэл* https://www.umch.ub.gov.mn/news/mn<br>- *Барилга байгууламжийн дуудлага худалдаа* https://www.umch.ub.gov.mn/news/mn?category=3<br>- *Түрээсийн сонгоон шалгаруулалтын зар, урилга* https://www.umch.ub.gov.mn/news/mn?category=4<br>- *Тээврийн хэрэгслийн дуудлага худалдаа* https://www.umch.ub.gov.mn/news/mn?category=2 ,<br>- *Эрх зүйн актууд* https://www.umch.ub.gov.mn/transparency/1/mn ,<br>- *Газрын даргын тушаал* https://www.umch.ub.gov.mn/transparencies/6/1 ,<br>- *Хүний нөөцийн ил тод байдал, албан тушаалын тодорхойлолт, ажлын байрны сул орон тоо, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр* https://www.umch.ub.gov.mn/transparency/3/mn,<br>- *Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний гишүүний мэдээлэл* https://www.umch.ub.gov.mn/storage/tranparency-values/May2023/RLtfSIYLPjiPryotLVP2.pdf .<br>- *Төсөв санхүүгийн ил тод байдал, Шилэн дансны мэдээлэл* https://shilendans.gov.mn/organization/11573?ry=2024 ,<br>- *Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө* https://www.umch.ub.gov.mn/transparencies/15/3/2890/mn | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - *Төрийн үйлчилгээ цэсэд дуудлага худалдаанд оролцох хүсэлт, шинээр хөрөнгө худалдан авах, хандив зээл тусламжийн хөрөнгө бүртгэх, хөрөнгө данснаас хасах, түрээсийн гэрээний загвар, Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээний загвар, хавсралтууд https://www.umch.ub.gov.mn/service/mn*<br>- *Цаг үеийн холбоотой мэдээллийг олон нийтэд https://www.facebook.com/umch.ub.gov.mn?ref=embed_page*<br><br>2.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг зэрэг холбогдох мэдээллийг хянан ажиллаж байна. Үүнд:<br>*1. Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ https://www.usug.ub.gov.mn/*<br>*2. Орон сууц аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ https://osnaaug.online/*<br>*3. Хот төлөвлөлт судалгааны институт ОНӨААТҮГ https://upri.ub.gov.mn/*<br>*4. Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ https://hihug.ub.gov.mn/website/home.aspx*<br>*5. Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ https://www.weddingpalace.mn/*<br>*6. Хөрөнгө оруулалтын газар ХК https://invest.ub.gov.mn/*<br>*7. Улаанбаатар хөгжлийн корпораци ХК https://ubdc.mn/home*<br>*8. Нийслэлийн Орон сууцны корпораци ХК https://nosk.ub.gov.mn/en_GB/jobs*<br>*9. Олон улсын худалдаа логистикийн төв ХК https://auto22.mn/* | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | *10. Улаанбаатар спорт менежмент https://usm.mn/mn.jsp*<br>*11. Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ХХК https://www.ubim.mn/*<br>*12. Эмээлт эко аж үйлдвэрийн парк https://www.emeeltpark.mn/*<br>*13. Төв цэнгэлдэх хүрээлэн ХК засвартай*<br>*14. Улаанбаатар смарт карт ХХК засвартай*<br>*15. Багачууд хүнс ОНӨААТҮГ https://bagachuudkhuns.ub.gov.mn/*<br>*16. Өсвөр-Үе хүнс ОНӨААТҮГ*<br>*17. https://shilendans.gov.mn/organization/11333?rfor=122443&rf=1112&rm=1&ry=2024*<br>*18. Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ*<br>*19. https://ubroad.ub.gov.mn/?playlist=820dd0c&video=366d07e*<br>*20. Хүнс хангамж төв ОНӨААТҮГ*<br>*21. https://old.shilendans.gov.mn/org/5276*<br>*22. Асгат ОНӨААТҮГ https://asgat.ub.gov.mn/*<br>*23. Хот тохижилтын газар ОНӨААТҮГ https://htg.ub.gov.mn/*<br>*24. Геодези усны барилга байгууламж https://gubb.ub.gov.mn/*<br>*25. Зорчигч тээвэр нэг https://transport.ub.gov.mn/*<br>*26. Зорчигч тээвэр хоёр / шинээр байгуулагдсан /*<br>*27. Зорчигч тээвэр гурав https://bus3.ub.gov.mn/*<br>*28. Зорчигч тээвэр дөрөв / шинээр байгуулагдсан /*<br>*29. Зорчигч тээвэр тав / шинээр байгуулагдсан /* | |
| 53 | Арга хэмжээ: 4.1.2 Нийслэл, орон нутгийн өмчийн бүртгэл, мэдээллийн цогц | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | Нийслэлийн 2023 оны А/1529 дүгээр захирамжаар төсөл арга | Нийслэлийн орон нутгийн өмчийн бүртгэлийн мэдээллийн цогц систем нэвтрүүлэх | "Нийслэлийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын систем"-д нийслэлийн өмчийн хөрөнгийг дэлгэрэнгүй шинж чанар бүрээр, цаг хугацаа алдагдалгүй бүртгэх, үл хөдлөх хөрөнгө, газар г.м хөрөнгийн бүртгэлийг ХУР мэдээллийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | систем, программ хангамжийг нэвтрүүлэх | | | хэмжээ хэрэгжүүлэх санхүүжилт батлагдсан. | холбогдох ажлын хэсэгт орж ажиллана. Мэдээллийн системийн ажлын даалгавар боловсруулах ажилд санал өгсөн байна. | сантай холбох, "Төрийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын нэгдсэн систем"-п холбож дэд модуль хэлбэрээр ажиллах, нийслэлийн өмч бүртгэх процессыг программ хангамжаар дамжуулан хийх, сангуудаас мэдээлэл татах боломжийг бүрдүүлэх, хөрөнгийн ангилал бүрээр батлагдсан маягтын дагуу нэгдсэн тайлан гаргах, хөрөнгийн тогтоол шийдвэр оруулах, шилжилт хөдөлгөөн, худалдах, дуудлага худалдааг нээлттэй болгон иргэдэд хялбар байдлаар худалдан авах нөхцөлийг нээх, гар утсанд суурилсан аппликэйшин нэвтрүүлэх ажил хийгдэж байна.<br>Хэрэглэгчийн удирдлагыг хэрэглэгчийн дүр тус бүрээр тохируулан ДАН системээр нэвтрэх программ хангамжийг 4 үе шаттайгаар боловсруулсан. Үүнд:<br>1-р үе шат:<br>Өгөгдлийн сангийн загвар, ERD зураг гарган, сангийн өгөгдлүүдийн зургийг хавсарган, хүснэгтийг гаргасан. Системийн топологи зургийг гарган хөгжүүлэгдэн Application server, Database server-т байршиж ажиллана. Шаардлагатай мэдээллийг татах, илгээх, дундын сан бий болгох системүүдийн судалгаа, байгууллагын дүрэм журмын судалгаа, системийн хөгжүүлэлтэд дагаж мөрдөх дүрэм журмуудыг /НИТХ-ын 2014 оны 55, 65, 66, 67-р тогтоол/ судалсан.<br>2-р үе шат: Техникийн даалгаварт тусгагдсан тоног төхөөрөмжүүдийг нийлүүлсэн. Үүнд:<br>- *Зөөврийн компьютер-5*<br>- *Компьютер- 45*<br>- *Таблет -4*<br>- *Хувилагч - 2*<br>- *Олон үйлдэлт төхөөрөмж- 8*<br>- *Өнгөт принтер- 1*<br>- *Скайнер - 2*<br>3-р үе шат: Төслийн менежментийн ажлууд бүрэн хийгдсэн. Үүнд: | |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>- Техникийн даалгаварт дүн шинжилгээ хийж системийн цар хүрээ, ашиглах хэрэглэгчийн түвшин тодорхойлон дэд систем бүр дээр хэрэглэгчийн шаардлагыг тодорхойлсон,<br>- НӨХГ-ын нэгжийн чиг үүргийг судалсан,<br>- Хэрэглэгчийн шаардлагад тулгуурлан үйл ажиллагааны процессыг тодорхойлж, захиалагчаар хянуулж баталгаажуулсан,<br>- Процесс диаграммуудыг гарган, захиалагч талын үйл ажиллагааны онцлогийг сайжруулах процесс зургуудыг гарган, баталгаажуулсан.<br>- Модуль бүрийн жагсаалт, бүртгэлийн дэлгэрэнгүй формын агуулга, загварын саналыг захиалагчаас авч, тусгасан.<br>- Ерөнхий дизайн компонентыг, баталгаажуулж, бүх формуудыг гаргасан.<br>- Одоогийн нөхцөл байдлын судалгааг гарган, сайжруулж, цахимд оруулах боломжийг судлан, гаргасан<br>- Системийг ажиллагаа, оролт, гаралтын утгуудыг захиалагчид хүргүүлсэн.<br><u>4-р үе шат. Системийн хөгжүүлэлтийн явцад бүх модулиуд хийгдэж дууссан.</u><br>Хөгжүүлэлтэд өгөхөд захиалагчтай модуль бүрийн дэлгэцийн зураг, процессыг хянаж, баталгаажуулсан. Модуль хөгжүүлэлтэд:<br>- Хуулийн этгээдийн мэдээлэл,<br>- Өмчийн бүртгэл (Хуулийн этгээд,<br>- Хөрөнгийн хөдөлгөөн,<br>- Тооллогын систем,<br>- Тайлан мэдээ,<br>- Архивын систем,<br>- Санхүүгийн тайлан,<br>- Системийн дотоод хяналт,<br>- Хэрэглэгчийн тохиргоо,<br>- Өмчийн хяналт шалгалтын систем,<br>- Тусламж,<br>- Систем, дэд систем тус бүрийн нэгжийн болон ачааллын тест,</td><td></td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - *Хэрэглэгчид танилцуулж, хэрэглэгчийн тест,*<br>- *Дэд системийн сайжруулалт,*<br>- *Суурь платформын сайжруулалт,*<br>- *Функциональ түвшний хэрэглэгчийн сургалт зохион байгуулах,*<br>- *Системийн хэрэглэгчдэд сургалт зохион байгуулах;*<br>- *Систем хүлээлцэх, эцсийн тайлан.* | |
| 54 | Арга хэмжээ: 4.1.3<br>Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээг цахимд оруулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авах | - | Цахимжуулсан үйлчилгээ | - | Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн дагуу эрхлэн явуулж байгаа төрийн үйлчилгээг цахимд оруулах ажлыг эхлүүлсэн байна. | Төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үзүүлэх үйлчилгээний хүрээнд байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүрэгт хамаарах барилга байгууламж, тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлага худалдаа зохион байгуулах, хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулах, түрээсийн гэрээ байгуулах зэрэг ажлыг цахимд оруулахаар саналыг хүргүүлээд байна.<br>Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан Нийслэл, орон нутгийн өмчийн бүртгэл, мэдээллийн цогц систем, программ хангамжийг нэвтрүүлэх зорилтуудыг хүрээнд "Нийслэлийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын систем"-д хөрөнгийн тогтоол шийдвэр оруулах, шилжилт хөдөлгөөн, худалдах, дуудлага худалдааг нээлттэй болгон иргэдэд хялбар байдлаар худалдан авах нөхцөлийг нээх, гар утсанд суурилсан аппликэйшин нэвтрүүлэх ажил хийгдэж байна. | 100% |
| 55 | Арга хэмжээ: 4.1.4<br>Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан UBlegal.ulaan-baatar.mn цахим хуудаст байгууллагын даргын тушаалуудыг байршуулж мэдээлэх ажлыг зохион байгуулах | - | Тушаалын тоо | UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудаст байгууллагын газрын даргын 54 тушаалуудыг байршуулсан. | Газрын даргын хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой тушаалыг тухай бүр бүртгэсэн байна. | Газрын даргын хариуцлагын гэрээний дагуу байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх чиглэлээр Ublegal.ulaanbaatar.mn цахим хуудаст 2024 оны "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын хурлаар хэлэлцүүлэн батлуулсан, нийслэлийн өмчийн болон, төсөвт байгууллагуудын хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой 500 газрын даргын А тушаалыг бүртгэн, төрийн байгууллагууд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болон олон нийт танилцах боломжоор хангаж ажилласан. | |
| 56 | Арга хэмжээ: 4.1.5 Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох дүрэм, журам болон стандартыг байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллах, албан хаагчдын боловсруулсан баримт бичиг нь "Баримт бичгийн стандарт" MNS 5140:2021 хангуулсан байх, EDOC системд ирсэн, явсан бичгийн бүртгэл хөтлөн, шийдвэрлэх | - | -Нийт албан бичгийн тоо<br>-Хугацаа хэтэрсэн албан бичгийн тоо<br>-Шийдвэрлэлтийн хувь<br>-Шийдвэрлэлтийн хугацаа | 3432 албан бичиг ирснээс хариутай 457, хариугүй 2975, хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь 98.54%, хариугүй бичгийн шийдвэрлэлийн хувь 99.6%, шийдвэрлэлтийн дундаж хугацаа (30 хоног) 7.24 үнэлгээтэй байна. Явуулсан албан бичиг нийт 1496 байгаагаас хариутай 415, хариугүй 1081 бичиг байна. Үүнээс 280 албан бичгийг шуудангаар буюу цаасан хэлбэрээр илгээсэн. | Албан хэрэг хөтлөлт, стандарт хангагдсан байна. | Тайлант хугацаанд нийт 3840 албан бичиг ирснээс хариутай 551, хариугүй 3289, хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь 97.62%, хариугүй бичгийн шийдвэрлэлийн хувь 99.33% байна. Нийт ирсэн бичгээс 3633 хугацаанд нь шийдвэрлэж, 219 бичиг судлагдаж байгаа төлөвт байна. Албан бичгийн зөрчил 266 байгаагаас явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил хамгийн их хувийг эзэлсэн байна.<br><br>Явуулсан албан бичиг нийт 2055 байгаагаас хариутай 584, хариугүй 1471 бичиг байна. Үүнээс 362 албан бичгийг шуудангаар буюу цаасан хэлбэрээр илгээсэн. 2024 оны эхний хагас жилийн байдлаар 2024.10.14-нд 1000 ширхэг тушаалын баланк, 2024.10.14-нд 250 ширхэг A4 албан бичгийн баланкыг Нийслэлийн архивын газраас захиалан ашиглаж байна.<br>Албан хаагчид ирсэн бичгийг шийдвэрлэхдээ албан бичгийн стандартын дагуу үндэслэлтэй тайлбар бичсэн, 10 хоног тутам явцын тэмдэглэл бичсэн эсэхэд хяналт тавин ажиллаж байна | 100% |
| 57 | Арга хэмжээ: 4.1.6 Нийслэлийн дотоод удирдлагын систем UB ERP системийн өргөдөл гомдол шийдвэрлэлт дэд цэсэд бүртгэгдсэн иргэд аж ахуй нэгжээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хүлээн авах, судлах, хугацаанд нь шийдвэрлүүлж, тайлагнах | - | -Өргөдөл гомдолд нэг мөр хариу өгөх<br>-Шийдвэрлэл-тийн дундаж хугацаа<br>-Зөрчил тооцуулахгүй байх<br>-Тайланг улирал бүр нэгтгэсэн байх | 2023 онд нийт 101 өргөдөл, гомдлыг хүлээн авсан. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хоног өмнөх оноос 3 хоногоор буурч, 5 хоног 7 цаг 15 минут байна. | Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацааг 10 хоногоос хэтрүүлэхгүй, 100% шийдвэрлэсэн байна. Дээд шатны байгууллагад хугацаанд нь тайлагнасан байна. | Нийслэлийн дотоод удирдлагын систем UB ERP системийн өргөдөл гомдол шийдвэрлэлт дэд цэсэд бүртгэгдсэн иргэд аж ахуй нэгжээс ирүүлсэн 141 өргөдөл гомдлыг хүлээн авах, судлах, хугацаанд нь шийдвэрлэсэн. НЗДТГ-т 14 хоног бүр тайлагнан ажилласан. Тайлант хугацаанд нийт 141 өргөдөл, гомдол ирснээс шийдвэрлэсэн 137, судалж байгаа 4 байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7 хоног 0 цаг 10 минут байгаа нь өмнөх оноос бууруулан ажилласан болно.<br>Үүнээс Засгийн газар, иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөс 9 өргөдөл, гомдол ирснийг бүрэн шийдвэрлэн хариуг албан бичгээр хүргүүлсэн. | 100% |
| 58 | Арга хэмжээ: 4.1.7 Архивын тухай хууль, Архив, албан хэрэг | - | -Хуваарь батлуулсан байх | Байгууллагын Архивын сан хөмрөгт 2015- | Нийт **180** хадгаламжийн нэгжийг бүртгэн | Газрын даргын 2024 оны А/487 дугаар тушаалаар Баримт нягтлан шалгах комиссыг шинэчлэн байгуулсан. Байгууллагын архивд 1991- | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | https://www.umch.ub.gov.mn/storage/tranparency-values/-May2023/RLtfSIYLPjiPryotLVP2.pdf нээлттэй байршуулж, "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган мэдээллийг Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Авлигатай тэмцэх газар, НЗДТГ-т хүргүүлэн ажилласан.<br>Нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Удирдах зөвлөл, Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг өөрчлөх тухай НИТХТ-ын тогтоолын төсөл боловсруулан батлуулсан. Үүнд:<br>- *НИТХ-ын 2024 оны 22 дугаар тогтоолоор 20 хуулийн этгээдийн 20 гишүүнийг чөлөөлөх,*<br>- *НИТХ-ын 2024 оны 23 дугаар тогтоолоор 16 хуулийн этгээдийн 38 гишүүнийг томилох,*<br>- *НИТХ-ын 2024 оны 46 дугаар тогтоолоор 3 хуулийн этгээдийн 6 гишүүнийг чөлөөлж, 2 гишүүн томилох,*<br>- *НИТХ-ын 2024 оны 81 дүгээр тогтоолоор 10 хуулийн этгээдийн 10 гишүүний чөлөөлөх,*<br>- *НИТХ-ын 2024 оны 83 дугаар тогтоолоор 1 хуулийн этгээдийн 5 гишүүдийг чөлөөлж, 6 гишүүд томилох,*<br>- *НИТХ-ын 2024 оны 84 дүгээр тогтоолоор 1 хуулийн этгээдийн 5 гишүүнийг томилох,*<br>- *НИТХ-ын 2024 оны 101 дүгээр тогтоолоор 20 хуулийн этгээдийн 51 гишүүдийг чөлөөлөх,*<br>- *НИТХ-ийн 2024 оны 102 дугаар тогтоолоор 12 хуулийн этгээдийн 12 гишүүнийг томилох,*<br>- *НИТХ-ийн 2024 оны 118 дугаар тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 гишүүнийг чөлөөлж, 4 гишүүн томилох,*<br>- *НЗД-ын 2024 оны 01/6612 дугаар албан бичгээр нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой 18 хуулийн этгээдийн УЗ болон ТУЗ-ний гишүүдийг чөлөөлж, томилох тогтоолын төсөл боловсруулан өргөн барьсан.* | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | https://www.umch.ub.gov.mn/storage/tranparency-values/-May2023/RLtfSIYLPjiPryotLVP2.pdf нээлттэй байршуулж, "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаан мэдээллийг Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Авлигатай тэмцэх газар, НЗДТГ-т хүргүүлэн ажилласан.<br>Нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Удирдах зөвлөл, Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг өөрчлөх тухай НИТХТ-ын тогтоолын төсөл боловсруулан батлуулсан. Үүнд:<br>- *НИТХ-ын 2024 оны 22 дугаар тогтоолоор 20 хуулийн этгээдийн 20 гишүүнийг чөлөөлөх,*<br>- *НИТХ-ын 2024 оны 23 дугаар тогтоолоор 16 хуулийн этгээдийн 38 гишүүнийг томилох,*<br>- *НИТХ-ын 2024 оны 46 дугаар тогтоолоор 3 хуулийн этгээдийн 6 гишүүнийг чөлөөлж, 2 гишүүн томилох,*<br>- *НИТХ-ын 2024 оны 81 дүгээр тогтоолоор 10 хуулийн этгээдийн 10 гишүүний чөлөөлөх,*<br>- *НИТХ-ын 2024 оны 83 дугаар тогтоолоор 1 хуулийн этгээдийн 5 гишүүдийг чөлөөлж, 6 гишүүд томилох,*<br>- *НИТХ-ын 2024 оны 84 дүгээр тогтоолоор 1 хуулийн этгээдийн 5 гишүүнийг томилох,*<br>- *НИТХ-ын 2024 оны 101 дүгээр тогтоолоор 20 хуулийн этгээдийн 51 гишүүдийг чөлөөлөх,*<br>- *НИТХ-ийн 2024 оны 102 дугаар тогтоолоор 12 хуулийн этгээдийн 12 гишүүнийг томилох,*<br>- *НИТХ-ийн 2024 оны 118 дугаар тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 гишүүнийг чөлөөлж, 4 гишүүн томилох,*<br>- *НЗД-ын 2024 оны 01/6612 дугаар албан бичгээр нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой 18 хуулийн этгээдийн УЗ болон ТУЗ-ний гишүүдийг чөлөөлж, томилох тогтоолын төсөл боловсруулан өргөн барьсан.* | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж, байгууллагын архивын сан хөмрөгийг бүрдүүлэх | | -Архивд материал хүлээн авах | 2022 оны байнга хадгалах нийт 1646 баримт хадгалагдаж байна. Үүнээс 2004-2022 оны түр хадгалах 2408 хадгаламжийн нэгж, 1991-2022 оны 70 жил хадгалах 99 баримт тус тус байна. Байгууллагын Архивын сан хөмрөгт 2015-2022 оны байнга хадгалах нийт 1646 баримт хадгалагдаж байна. Үүнээс 2004-2022 оны түр хадгалах 2408 хадгаламжийн нэгж, 1991-2022 оны 70 жил хадгалах 99 баримт тус тус байна. | архивын сан хөмрөгийг бүрдүүлнэ. Байгууллагын 2016-2022 оны байнга хадгалах баримтыг Нийслэлийн Архивын газарт шилжүүлсэн байна. ББНШК-ын хурлыг зохион байгуулах холбогдох арга хэмжээ авч ажиллана. | 2022 оны нийт 4149 баримт хадгалагдаж байгаагаас:<br>- *байнга хадгалах 1629,*<br>- *түр хадгалах 2422,*<br>- *70 жил хадгалах 98,*<br>- *Захирамжлахын баримт А, Б тушаалын CD 4 ширхэг, DVD 2 ширхэг байна.*<br><br>Үйл ажиллагааны хүрээнд 2023 онд үүссэн 226 хадгаламжийн нэгжээр архивын сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлтийг хийсэн. Нийслэлийн Архивын газрын Archive eDOC нэгдсэн системд 2215 хуудас шивж, сканердан PDF оруулж батлан шалгуулсан. Үүнд:<br>- *2023 оны байнга хадгалах "А" тушаал 01-611 дугаар бүхий 2075 хуудас,*<br>- *70 жил хадгалах "Б" тушаал 01-122 дугаар бүхий 140 хуудас*<br><br>Нийслэлийн Архивын газарт 2015-2022 оны архивын баримт шилжүүлэх ажлын хүрээнд:<br>- *2015-2022 оны даргын "А" тушаалыг нягтлан шалган 2017-2020 оны нийт 33 боть тушаал цахимд оруулаагүй, алгассан, давхардсан дугаарын тэмдэглэгээ хийгдээгүй байсныг цаасан суурьт баримтыг задалж сканердан цахим хувийг үйлдэн CD, DVD дээр хуулбарласан*<br>- *70 жил хадгалах 2015-2022 оны баримтын нийгмийн даатгал төлөлтийн тооцооны хуудас, цалингийн хүснэгт, цалингийн картыг салган дугаарлах, товьёглох, хавтаслах, үдэж бүртгэсэн,*<br>- *Байнга хадгалах 1629 баримтын 1015 баримтын ар өвөргүй бичвэртэй, дугаарлалт алгасныг дугаарлан, давхардсан тоогоор 983 баримтын нүүр бичилтийг хийх, хавтаслах, үдэх, товьёг дахин шинээр шивж үйлдсэн,*<br>- *Байнга, түр, 70 жил хадгалах 2015-2022 оны баримтуудаас санхүүгийн жилийн тайлан,* | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | *батлагдсан төсөв, гүйцэтгэлийн мэдээ, аудитын тайлан, татварын тайлан, нийгмийн даатгалын төлөлтийн тайлан, жилийн эцсийн тооллогын бүртгэлийг нөхөн бүрдүүлсэн,*<br>- *Байнга хадгалах баримтын Баримт нягтлан шалгах комисс шалгаж Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын 288, Төрийн болон орон нутгийн өмчийн дахин үнэлгээний 351, Үдийн цайны хөтөлбөрийн түрээсийн гэрээ, сонгон шалгаруулалтын баримт, Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ 117, нийт 656 баримтыг түр хадгалах хадгаламжийн нэгжийн данс бүртгэлд бүртгэсэн.*<br>- *2015-2022 онд үүссэн түр хадгалах 149 баримтаас хуулбарласан, давхардсан баримтыг устгах хэргийн баримтад шилжүүлсэн. Баримт нягтлан шалгах комиссын 1 дүгээр хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж данс бүртгэлийг үйлдсэн.* | |
| Хэрэгжилтийн дундаж оноо __100__ | | | | | | | |

Төлөвлөгөөг хянасан: Төсвийн Ерөнхийлөн захирагч

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ ......................... /Х.НЯМБААТАР/
(албан тушаал) (гарын үсэг)

(огноо)
Тэмдэг ..............................

Төлөвлөгөө тайлагнасан: Төсвийн Шууд захирагч
НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ......................... /В.ОЮУМАА/
(албан тушаал) (гарын үсэг)

(огноо)
Тэмдэг ..............................

-o0o-